МУБИС-ийн ректорын 2025 оны 01. дүгээр сарын 23-ний
өдрийн А128 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

# МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН ИХ СУРГУУЛИЙН ЦАХИМ ШИЛЖИЛТИЙН ХӨТӨЛБӨР /2025-2027, 2028-2030 он/

## Нэг. Үндэслэл, хэрэгцээ

"Тогтвортой хөгжлийн зорилго" бодлогын баримт бичиг; Боловсролын ерөнхий хууль; "Алсын хараа 2050" Монгол Улсын хөгжлийн урт хугацааны баримт бичиг; Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр; Боловсролын салбарын дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөө, 2021-2030; Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл; "Цахим үндэстэн", 2022-2027, Дунд хугацааны хөтөлбөр; Монгол улсын Боловсролын салбарын цахим шилжилтийн төлөвлөгөө, 2022-2026; Монгол улсын боловсролын их сургуулийн стратеги төлөвлөгөө (2025-2030) зэрэг бодлогын баримт бичгүүдэд цахим шилжилттэй хамааралтай тодорхой зүйл заалтууд тусгагдсан байдаг. Мөн МУБИС-ийн стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх үүднээс МУБИС-ийн цахим шилжилтийн хөтөлбөрийг боловсруулах хэрэгцээ, шаардлага бий болсон.

Энэхүү хөтөлбөр нь МУБИС-ийн үнэт зүйл, эрхэм зорилготой уялдаж, МУБИС-ийн дижитал соёл, хүний нөөцийн цахим ур чадварыг хөгжүүлэх, технологийн цогц өөрчлөлт хийх, дижитал үйлчилгээний хүртээмж, чанар, үр нөлөө, бүтээмжийн хувь хэмжээг нэмж, цахим шилжилтийн хөгжлийн хурдасгахад чиглэгдэнэ.

## Хоёр. Хамрах хүрээ

МУБИС-ийн цахим шилжилтийн хөтөлбөр нь дараах хүрээг хамарна. Үүнд, МУБИС-ийн дижитал орчин багшлахуй, эрдэм шинжилгээний ажил ба суралцахуйн туршлагыг дэмжих, амжилттай ажиллах боломжийг бий болгох талаарх иж бүрэн хэтийн төлөвийг тусгасан. Мөн уг хөтөлбөрт МУБИС-ийн стратегийн алсын хараа болон төлөвлөлтийн хөгжүүлэлт, инновацыг дэмжих, бизнесийн үйл явц, үйл ажиллагааг оновчтой болгох, хамтын ажиллагааны түншлэлийг өргөжүүлэхэд хөтөч болох бүтцийг тусгав. МУБИС-ийн Цахим шилжилтийн хөтөлбөр дараах 6 бүрдүүлбэр хэсэгтэй. Үүнд:

1. МУБИС-ийн дижитал соёл: Үнэт зүйлс, итгэл үнэмшил, байгууллагын сайн сайхан байдал, ондоошил, өөрчлөлтийн асуудлыг хамарна.
2. Мэдлэг бүтээх ба инновац: МУБИС-ийн эрдэм шинжилгээ, судалгаа, инновацтай холбоотой асуудлыг хамарна.
3. Мэдлэгийн хөгжүүлэлт: МУБИС-ийн бүх түвшний сургалтын үйл ажиллагааг хамарна.
4. Мэдлэгийн менежмент ба хэрэглээ: МУБИС-ийн мэдээлэл, өгөгдлийн сан, хадгалалт, номын сан, өгөгдлийн сангийн менежменттэй холбоотой асуудлыг хамарна.
5. Мэдээллийн солилцоо ба түншлэл: МУБИС-ийн дотоод болон гадаад хамтын ажиллагаа, харилцааны асуудлыг хамарна.
6. МУБИС-ийн дижитал дэд бүтэц: МУБИС-ийн сүлжээ, дижитал орчинтой холбоотой асуудлыг хамарна.




**Гурав. Цахим шилжилтийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат, хугацаа**

Хөтөлбөрийг 2025-2027 ба 2028-2030 гэсэн хоёр үе шаттай хэрэгжүүлнэ. Цахим технологийн хөгжил хурдацтай хөгжилтэй уялдуулан гурван жилд нэг удаа үнэлгээ хийн сайжруулж, 2028 онд өөрчлөлт оруулна.

| I үе шат (2025-2027) | **ҮНЭЛЭХ** | II үе шат (2028-2030) |
| --- | --- | --- |
| **ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ** | **ЗОРИЛТЫГ ҮНЭЛЭХ ҮЕ** | **ЗОРИЛТЫГ ХЭВШҮҮЛЭХ ҮЕ** |
| МУБИС-ийн цахим шилжилтийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд бүх удирдлага, багш, ажилчид идэвхийлэн оролцох үе | Цахим шилжилтийн хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх, сайжруулах, шинэчлэх үе | МУБИС-ийн цахим шилжилтийн хөтөлбөрийн үр дүнг хэвшүүлэх, түгээн дэлгэрүүлэх үе |

## Дөрөв. Цахим шилжилтийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарчим

Тэмүүллээр түүчээлж, бэлэн байдлыг үнэлж, нийгэм дэх манлайллыг бүтээж, хэрэгжүүлэлтийг оновчтой зохион байгуулж, шинжлэн нягтлах зарчмыг баримтална. Хөтөлбөрийн хэрэгжүүлэлт зарчмын зураглалыг дор харуулав.



**Тав. Хөтөлбөрийн зорилгыг хэмжих шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшин, стратеги**

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх I шат (2025-2027)*
Хөтөлбөрийг хэрэгжүүлэх II шат (2028-2030)**

| Бодлогын баримт бичигт тусгагдсан, болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилго | Стратеги /арга зам/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин /2024 он/ | Зорилтот түвшин | I шат*, II шат** | Санхүүгийн эх үүсвэр, Хариуцах нэгж |
|---|---|---|---|---|---|---|
| **1. МУБИС-ийн дижитал соёл** | | | | | | |
| **Зорилго 1.** Үнэт зүйлс, итгэл үнэмшилд тулгуурласан стратегийн бодлогодоо дижитал технологийн шинэчлэл, өөрчлөлтийг тусгаж, түүнд дасан зохицохуйц хүний нөөцийн чадавхыг хөгжүүлж МУБИС-ийн дижитал соёлыг цогцлоох. | | | | | | |
| 1.1. Дижитал соёл ба сэтгэлгээ<br><br>**Хамрах хүрээ:** Хүртээмжтэй байдал; Дижитал манлайлал; Дижитал ур чадвар; Цахим шилжилтийн хөтөлбөр; Алсын хараа; Засаглал; Байгууллагын үнэт зүйл. | 1.1.1. Байгууллагын эрхэм зорилго, үнэт зүйлс, зарчим, цахим шилжилт зэргийг тусгасан оролцогч талуудыг нэгдсэн ойлголттой болгох зориулалт бүхий нэр томьёоны цахим тайлбар толийг бий болгох. | Цахим шилжилтийн нэр томьёоны цахим тайлбар толь | Цахим шилжилтийн нэр томьёоны цахим тайлбар толь байхгүй. | Байгууллагын эрхэм зорилго, үнэт зүйлс, зарчим, цахим шилжилт зэргийг тусгасан оролцогч талуудыг нэгдсэн ойлголттой болгох зориулалт бүхий нэр томьёоны цахим тайлбар толийг веб сайтад байрлуулсан байна. | I шат | МУБИС |
| **Зорилт 1.1.** МУБИС-ийн эрхэм зорилго, үнэт зүйлстэй нийцсэн, оролцогч талуудын оролцоог дэмжиж байгууллагын | 1.1.2. Боловсролын болон МУБИС-ийн үйл ажиллагаатай холбоотой бодлого, дүрэм, журмуудын интерактив санг үүсгэх. | Бодлого, дүрэм, журмуудын интерактив сан | МУБИС-ийн үйл ажиллагаатай холбоотой бодлого, дүрэм, журмууд PDF файл хэлбэртэй. | Боловсролын болон МУБИС-ийн үйл ажиллагаатай холбоотой бодлого, дүрэм, журмуудын интерактив сантай болно. | I шат | Батлагдсан төсөв, СЦШХ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| дижитал соёлыг хөгжүүлэх, бүрдүүлэх. | 1.1.3. МУБИС-ийн үйл ажиллагааны төлөвлөгөө, тайланг нэгтгэх, үнэлэх, хэвлэх системийг хөгжүүлэх. | МУБИС-ийн үйл ажиллагааны төлөвлөгөө, тайланг нэгтгэх, үнэлэх, хэвлэх систем. | МУБИС-ийн үйл ажиллагааны төлөвлөгөө, тайланг MS excel файлаар нэгтгэж, хэвлэдэг. | МУБИС-ийн үйл ажиллагааны төлөвлөгөө, тайланг нэгтгэх, үнэлэх, хэвлэх системийг хөгжүүлсэн байна. | I шат | Батлагдсан төсөв болон санхүүгийн бусад эх үүсвэр, СЦШХ |
| | 1.1.4. Удирдлага, багш, ажилтан, ажилчдын дижитал ур чадвараа хөгжүүлэх сургалтын болон зөвлөн туслах үйлчилгээний нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх. | Удирдлага, багш, ажилтан, ажилчдын дижитал ур чадвараа хөгжүүлэх сургалтын болон зөвлөн туслах үйлчилгээний нэмэгдсэн хувь | Удирдлага, багш, ажилтан, ажилчдын дижитал ур чадвараа хөгжүүлэх сургалтын болон зөвлөн туслах үйлчилгээний нэгдсэн тогтолцоо байхгүй. | Удирдлага, багш, ажилтан, ажилчдын дижитал ур чадвараа хөгжүүлэх сургалтын болон зөвлөн туслах үйлчилгээний нэгдсэн тогтолцоог бүрдүүлнэ. | I, II шат | Батлагдсан төсөв, СЦШХ |
| | 1.1.5. Багш, ажилтны ажлын байрны тодорхойлолтод зайлшгүй эзэмших дижитал ур чадваруудыг тусгах | Шинэчлэгдсэн ажлын байрны тодорхойлолт | Ажлын байрны тодорхойлолтод зайлшгүй эзэмших дижитал ур чадварууд тусгагдаагүй. | Оролцогч талуудын ажлын байрны тодорхойлолтод зайлшгүй эзэмших дижитал ур чадваруудыг тусгасан байна. | I, II шат | МУБИС |
| 1.2. Байгууллагын ондоошил<br><br>**Хамрах хүрээ:** Хүртээмжтэй байдал; Дижитал манлайлал; Цахим шилжилтийн хөтөлбөр; Алсын хараа; Засаглал; Байгууллагын үнэт зүйл. | 1.2.1. Байгууллагын эрхэм зорилго, үнэт зүйлс, ондоошлыг тусгасан Монгол (кирилл, Монгол бичиг), Англи хэл бүхий маркетингийн тогтолцоог бүрдүүлэх. | Байгууллагын эрхэм зорилго, үнэт зүйлс, ондоошлыг тусгасан танилцуулгын Монгол болон Англи хувилбар | МУБИС-ийн веб сайт, зарим нийгмийн сүлжээгээр гол төлөв Монголоор сурталчилгааны мэдээллийг түгээдэг. | Байгууллагын эрхэм зорилго, үнэт зүйлс, ондоошлыг тусгасан Монгол болон Англи хэл дээрх маркетингийн тогтолцоог бүрдүүлсэн байна. | I шат | Батлагдсан төсөв, МУБИС |
| | 1.2.2. Оюутнууд болон ажилтнуудын дижитал орчин дахь зэрэг хандлагыг хөгжүүлж, | Зэрэг хандлагыг хөгжүүлж, эрсдэлээс хамгаалах ажлууд, тэдгээрийн тайлан | - | Оюутнууд болон ажилтнуудын дижитал орчин дахь зэрэг хандлагыг хөгжүүлэх, | I, II шат | Батлагдсан төсөв, Бүрэлдэхүүн сургууль |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 1.2.** МУБИС-ийн бусад их, дээд сургуулиас ялгарах өвөрмөц онцлогийг сурталчлах, нийгэм дэх нөлөөллийг нэмэгдүүлэх. | эрсдэлээс хамгаалах ажлыг зохион байгуулах. | | | эрсдэлээс хамгаалах ажлуудыг зохион байгуулсан байна. | | |
| 1.3. Байгууллагын сайн сайхан байдал<br><br>**Хамрах хүрээ:** Хүртээмжтэй байдал; Дижитал манлайлал; Цахим шилжилтийн хөтөлбөр; Алсын хараа; Засаглал; Хүний нөөц; Оролцогч талууд; Байгууллагын үнэт зүйл.<br>**Зорилт 1.3.** Багш, ажилтан, суралцагч нарын бие, сэтгэл санаа болон сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих дижитал технологийг МУБИС-ийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх. | 1.3.1. Оюутнууд болон багш, ажилтнуудад цахим аюулгүй байдал, цахим дээрэлхэлт, ёс зүйн хэм хэмжээг ойлгуулах, сургалт, сурталчилгаар зохион байгуулж, зэрэг хандлага төлөвшүүлэх. | Цахим аюулгүй байдал, цахим дээрэлхэлт, ёс зүйн хэм хэмжээг ойлгуулах, сургалт, сурталчилгааны ажил | Ёс зүйн хэм хэмжээг ойлгуулах, ухааруулах сургалт, сурталчилгаар цөөн тоогоор зохион байгуулдаг. | Оюутнууд болон багш, ажилтнуудад цахим аюулгүй байдал, цахим дээрэлхэлт, ёс зүйн хэм хэмжээг ойлгуулах, сургалт, сурталчилгаар зохион байгуулснаар байгууллагын зэрэг хандлага төлөвшил дээшилнэ. | I, II шат | Батлагдсан төсөв, МУБИС |
| | 1.3.2. Багш, ажилтнуудын эрүүл мэндэд ээлтэй дижитал орчин бүхий ажлын байрны загварыг бий болгож, хэрэгжүүлэх. | Эрүүл мэндэд ээлтэй ажлын байрны загвар орчин | Эрүүл мэндэд ээлтэй дижитал орчин бүхий ажлын байр бүрэн бүрэлдээгүй. | Багш, ажилтнуудын эрүүл мэндэд ээлтэй дижитал орчин бүхий ажлын байрны загварыг бий болгож, хэрэгжүүлсэн байна. | I шат | МУБИС |
| | 1.3.3. МУБИС-ийн нэгж үйл ажиллагааг удирдан чиглүүлэх, бүртгэх хүний нөөцийн (ERP) системийг нэвтрүүлэх | Хүний нөөцийн систем | https://erp.e-mongolia.mn/ системд багш, ажилчдын үндсэн мэдээллийг оруулж, цагийн бүртгэлд ашиглаж буй. | МУБИС-ийн нэгж үйл ажиллагааг удирдан чиглүүлэх, бүртгэх, хүний нөөцийн (ERP) системийг нэвтрүүлнэ. | I шат | МУБИС |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 1.4. Байгууллагын өөрчлөлт<br><br>**Хамрах хүрээ:** Хүртээмжтэй байдал; Кибер аюулгүй байдал; Дижитал орчны хөгжил; Хүний нөөц; Уян хатан ажиллах орчин; Оролцогч талууд; Ажилтны дэмжлэг.<br><br>**Зорилт 1.4.** МУБИС-ийн цахим шилжилтийн үйл ажиллагааны үр нөлөөг урьдчилан таамаглах, удирдан чиглүүлэх, хариу арга хэмжээ авах. | 1.4.1. Багш, ажилтнуудын санаачилсан инновацыг хөгжүүлэх, тэднийг урамшуулах, дэмжих, хөрөнгө оруулалт хийх тогтолцоог бий болгох. | Инновацыг дэмжих хөрөнгийн эх үүсвэр | Багш, эрдэмтдийг инновацыг бий болгох төслийг сонгон шалгаруулдаг. | Багш, ажилтнууд санаачилсан инновацыг, хөгжүүлэх, тэднийг урамшуулах, дэмжих, хөрөнгө оруулалт хийх тогтолцоо бий болсон байна. | I, II шат | МУБИС |
| | 1.4.2. Эрсдэлийг удирдах, инновацыг бий болгох, өөрчлөлтөд дасан зохицох чадвартай хүний нөөцийг хөгжүүлэх, удирдлагын дижитал ур чадварыг хөгжүүлэх. | Удирдлагын түвшинд ажиллаж буй хүмүүст дижитал ур чадварын сургалт | Хувь хүний зөөлөн ур чадваруудыг дээшлүүлэх сургалтууд гол төлөв зохион байгуулдаг. | МУБИС-ийн удирдлагын түвшинд ажиллаж буй хүмүүс дижитал ур чадварыг олгох сургалт зохион байгуулсан байна. | I, II шат | МУБИС |
| | 1.4.3. МУБИС-ийн цахим шилжилтийг хэрэгжүүлэх, хөгжүүлэх, турших, сайжруулах уян хатан бүтэц бүхий инкубатор төвийг байгуулах. | Инкубатор төв | Системийн хөгжүүлэлт, сайжруулалтыг ажлын хэсэг байгуулж, гадны компанитай гэрээ хийж гүйцэтгүүлдэг. | МУБИС-ийн системийн хөгжүүлэлт, сайжруулалтыг хийх инкубатор төвийг байгуулсан байна. | I шат | МУБИС |
| **2. Мэдлэг бүтээх ба инновац**<br>**Зорилго 2.** Эрдэм шинжилгээ, судалгаанд суурилсан хамтын ажиллагааны замаар нийтэд хүртээмжтэй үр дүнтэй эерэг нөлөөлөл үзүүлэх инновацыг бий болгох. | | | | | | |
| 2.1. МУБИС-ийн дижитал алсын хараа<br><br>**Хамрах хүрээ:** Дижитал стратеги; Ёс | 2.1.1. Багш боловсролоор бүс нутагтаа өрсөлдөхүйц их сургууль болох МУБИС-ийн алсын | МУБИС-ийн стратеги төлөвлөгөө болон Цахим шилжилтийн хөтөлбөрийн зорилтуудыг | - | МУБИС-ийн стратеги төлөвлөгөө болон цахим шилжилтийн хөтөлбөрийн зорилтуудыг | I шат | СХАГ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| зүй; Номын сан ба сургалтын нөөц; Нээлттэй судалгаа; Судалгааны хамтын ажиллагаа; Судалгааны менежмент ба дэмжлэг; Судалгааны ур чадварын хөгжүүлэлт ба сургалт.<br><br>**Зорилт 2.1.** Эрдэм шинжилгээ, инновац, сургалтын шинэ дижитал технологийг хөгжүүлж, боловсролын үйлчилгээний чанарыг орчин үеийн их сургуулийн түвшинд хүргэх. | харааг бодит болгох үүднээс МУБИС-ийн стратеги төлөвлөгөө болон цахим шилжилтийн хөтөлбөрийг бүх түвшинд хэрэгжүүлэх үүднээс алба, хэлтсийн дарга, бүрэлдэхүүн сургуулийн захирал, хөтөлбөрийн албаны дарга, тэнхимийн эрхлэгч нарт сургалт, семинар зохион байгуулах. | хэрэгжүүлэх нэгдсэн ойлголттой болох сургалт, семинар | | хэрэгжүүлэх талаар бүх нэгж, багш нар нэгдсэн ойлголттой болсон байна. | | |
| | 2.1.2. Сургуулийн удирдлагын баг хамт олны үйлдвэрлэл, эрдэм шинжилгээ, боловсрол, бизнесийн салбар дахь дижитал өөрчлөлтүүдийн талаарх мэдлэгийг дээшлүүлж, шинэ туршлага, арга барилыг (жишээлбэл, сургалтын хөтөлбөр боловсруулах, мэдлэг бүтээх) МУБИС-д хэрхэн тусгах талаар сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах. | Боловсрол, бизнесийн салбар дахь дижитал өөрчлөлтүүдийн талаар зохион байгуулсан сургалт, хэлэлцүүлэг | Зөвхөн тухайн салбарын мэргэжилтнүүдийн дунд хэлэлцүүлэг зохион байгуулагддаг. | Боловсрол, бизнесийн салбар дахь дижитал өөрчлөлтүүдийн талаар сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан байна. | I шат | ЭШИА |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 2.2. Эрдэм шинжилгээ<br><br>**Хамрах хүрээ:** Дижитал стратеги; Ёс зүй; Номын сан ба сургалтын нөөц; Нээлттэй судалгаа; Судалгааны хамтын ажиллагаа; Судалгааны менежмент ба дэмжлэг; Судалгааны ур чадварын хөгжүүлэлт ба сургалт.<br><br>**Зорилт 2.2.** Багш судлаачдыг татан оролцуулах, идэвхжүүлэх, хөгжүүлэх, дэмжих, судалгааны үр дүнд тохирсон хөрөнгө оруулалтыг дэмжих эрдэм шинжилгээний дижитал системийг бий болгох. | 2.2.1. Эрдэм шинжилгээний бүтээл (илтгэл, өгүүлэл, нэг сэдэвт бүтээл, төслийн тайлан)-ийг бүртгэх, нэгдсэн тайлан гаргах, дотоодын болон олон улсын судалгааны системүүдтэй мэдээлэл солилцох дижитал системийг хөгжүүлэх. | Эрдэм шинжилгээний бүтээлийн бүртгэл, түгээлтийн систем | МУБИС-ийн хуучин СУМС-д ийм төрлийн систем байсан боловч хэвийн үйл ажиллагаа жигдрээгүй. | Эрдэм шинжилгээний бүтээлийн нэгдсэн дижитал системийг хөгжүүлсэн байна. | I шат | Батлагдсан төсөв болон санхүүгийн бусад эх үүсвэр, ЭШИА |
| | 2.2.2. Судлаачдын хөгжлийг дэмжих, туршлагыг түгээх, судлаачийн ёс зүйн чиглэлээр онлайн курс хичээлийг хөгжүүлэх, сургалт зохион байгуулах. | Бүтээн хэрэгжүүлж буй онлайн курс | Судлаачдын хөгжлийг дэмжих, туршлагыг түгээх, судлаачийн ёс зүйн талаар онлайн курс байхгүй. | Судлаачдын хөгжлийг дэмжих, туршлагыг түгээх, судлаачийн ёс зүйг төлөвшүүлэх онлайн курс хичээлийг бүтээгдэж, хэрэгжүүлсэн байна. | I, II шат | Батлагдсан төсөв, ЭШИА |
| | 2.2.3. Бакалавр, магистр, докторын оюутнуудын болон эрдэмтэн багш нарын судалгааны өгөгдлийг нэг стандартаар цуглуулах, нээлттэй судалгааны их өгөгдлийн сантай болох суурийг бүрдүүлэх. | Судалгааны өгөгдлийн хадгалах, хэрэглэх стандарт | Бакалавр, магистр, докторын оюутнуудын болон эрдэмтэн багш нарын судалгааны өгөгдөл зөвхөн тухайн судлаачдад хадгалагддаг. | Бакалавр, магистр, докторын оюутнуудын болон эрдэмтэн багш нарын судалгааны өгөгдлийг нэг стандартаар цуглуулах, нээлттэй судалгааны их өгөгдлийн сантай болсон байна. | I шат | Батлагдсан төсөв болон санхүүгийн бусад эх үүсвэр, АТХА |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 2.2.4. Судалгааны өгөгдлийг боловсруулах лицензтэй программ хангамж, супер компьютерын үйлчилгээг сургалт, судалгаанд нэвтрүүлэх судалгаа хийх | Супер компьютерын үйлчилгээний нөхцөл, шаардлага | МУБИС-ийн хэмжээнд лицензтэй программ хангамж цөөн, супер компьютер байхгүй. | Лицензтэй программ хангамжийн тоон нэмэгдэж, супер компьютерын үйлчилгээг нэвтрүүлэх судалгааг хийсэн байна. | II шат | Гадаадын хөрөнгө оруулалт, ЭШИА |
| | 2.2.5. Ахисан түвшний суралцагчдын судалгааны менежментийн үйл явцыг хялбаршуулах, удирдан чиглүүлэх системийн модуль хөгжүүлэх. | Ахисан түвшний суралцагчдын судалгааны менежментийн системийн модуль | Ахисан түвшний суралцагчдын судалгааны ажлыг тэнхим болон удирдагч багш чиглүүлдэг. | Ахисан түвшний суралцагчдын судалгааны менежментийн үйл явцыг хялбаршуулах, удирдан чиглүүлэх системийн модулийг хөгжүүлсэн байна. | II шат | Батлагдсан төсөв болон санхүүгийн бусад эх үүсвэр, АТХА |
| 2.3. Инновац<br><br>**Хамрах хүрээ:** Дижитал стратеги; Дижитал бүтээлч байдал; Дижитал манлайлал; Судалгааны хамтын ажиллагаа.<br><br>**Зорилт 2.3.** МУБИС-ийн хөгжлийн бодлого, Цахим шилжилтийн хөтөлбөртэй нийцсэн дижитал манлайлал, | 2.3.1. МУБИС-ийн стратеги хөгжлийн бодлого, цахим шилжилтийн хөтөлбөрийн зорилтуудыг дэмжих дижитал инновацын төслүүдийг хэрэгжүүлэх. | Хэрэгжсэн инновацын төслүүдийн үр дүн, тайлан | Инновацын төслийг шалгаруулж, хэрэгжүүлдэг боловч хамрах хүрээ үр дүн харьцангуй бага байна. | МУБИС-ийн стратеги хөгжлийн бодлого, цахим шилжилтийн хөтөлбөрийн зорилтуудыг дэмжих дижитал инновацын төслүүдийг хэрэгжсэн байна. | I, II шат | Батлагдсан төсөв, ЭШИА |
| | 2.3.2. МУБИС-ийн инкубатор төвд зөвлөх, программист, оюутнууд түншээр ажиллах журам, ажлын байрны тодорхойлолт | Батлагдсан журам, ажлын байрны тодорхойлолт | Программистыг ажиллуулах хөлсөөр ажиллуулах гэрээ хийдэг. Харин, оюутныг орлоготой суралцагч гэсэн | МУБИС-ийн инкубатор төвд зөвлөх, программист, оюутнууд түншээр ажиллах журам, ажлын байрны | I шат | СЦШХ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| бүтээлч байдлыг дэмжих шинэ санаа, шийдлийг хөгжүүлэх инновацын бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх. | боловсруулж батлуулах. | | журмын заалтыг ашигладаг. | тодорхойлолтыг батлуулсан байна. | | |
| | 2.3.3. Дижитал бүтээлч байдлыг дэмжих, шилдэг санаа, инновацын бүтээгдэхүүнийг урамшуулах, шагнах, хөрөнгө оруулалт хийх төсвийн санг санхүүгийн дүрэм, журамд нийцүүлэн байгуулах. | Инновацын бүтээгдэхүүнд хөрөнгө оруулалт хийх төсвийн сан | Инновацын төслийг шалгаруулж, хэрэгжүүлдэг боловч хамрах хүрээ үр дүн харьцангуй бага | Дижитал бүтээлч байдлыг дэмжих, шилдэг санаа, инновацын бүтээгдэхүүнийг урамшуулах, шагнах, хөрөнгө оруулалт хийх төсвийн сантай болсон байна. | I, II шат | ЭШИА |
| | 2.3.4. Амжилттай хэрэгжсэн инновацын бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, үйлдвэрлэх, нийтэд түгээх гарааны компанийн анхны хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх МУБИС-ийн болон хувийн хэвшлийн санхүүжилтийн тогтолцоог бий болгох. | Гарааны компанийн анхны хөрөнгө оруулалтын сан, журам | Гарааны компанийг бойжуулсан тохиолдол харьцангуй цөөн | Амжилттай хэрэгжсэн инновацын бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, үйлдвэрлэх, нийтэд түгээх гарааны компанийн анхны хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх МУБИС-ийн болон хувийн хэвшлийн санхүүжилтийн механизм, тогтолцоо бүрдсэн байна. | II шат | ЭШИА |
| 2.4. Нийтэд нөлөөлөх нөлөөлөл<br><br>**Хамрах хүрээ:** Дижитал нийгэмлэгийг байгуулах; Гадаад | 2.4.1. Судалгаа, үйлдвэрлэл болон бизнесийн инновацын төслүүдийн сан бүрдүүлэх, орон нутаг, үндэсний, олон улсын | Судалгаа, үйлдвэрлэл болон бизнесийн инновацын төслүүдийн бүтээгдэхүүн, тайланд нөлөөллийн | Судалгааны, үйлдвэрлэл ба бизнесийн инновацын төслүүдийн тайланг цаасан хэлбэрээр цуглуулдаг боловч | Судалгааны, үйлдвэрлэл ба бизнесийн инновацын төслүүдийн сан бүрдүүлэх, орон нутаг, үндэсний, олон | I, II шат | Батлагдсан төсөв, ЭШИА |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| хамтын ажиллагаа; Дотоод хамтын ажиллагаа; Маркетинг; Үндэсний хэмжээний нөлөөлөл. | хэмжээнд үзүүлэх нөлөөлөлд шинжилгээ хийж, үнэлэх. | шинжилгээ хийсэн тайлан | нөлөөллийн шинжилгээ хийгддэггүй. | улсын хэмжээнд үзүүлэх нөлөөлөлд шинжилгээ хийж, үнэлсэн байна. | | |
| **Зорилт 2.4.** МУБИС-ийн эрдэм шинжилгээ, судалгааны болон инновацын төслүүдийн үр дүнг хэмжих, олон нийтэд түгээх маркетингийн тогтолцоог бий болгох. | 2.4.2. МУБИС-ийн дижитал хэвлэл мэдээлэл, контент, веб сайт, олон нийтийн сүлжээ сайтуудыг хөгжүүлэх, хариуцан ажилладаг мэргэжилтнүүдийн ур чадвар, туршлагыг сайжруулах сургалтад хамруулах, мэргэжил дээшлүүлэх. | Мэдээллийн технологийн мэргэжилтнүүдийг хамрагдсан сургалтын тоо | Мэдээллийн технологийн мэргэжилтнүүдийг хувь хүний зөөлөн ур чадварыг дээшлүүлэх сургалтад хамруулдаг. | Мэдээллийн технологийн мэргэжилтнүүдийг сургалтад хамруулсан байна. | I, II шат | Батлагдсан төсөв, СХАГ, ЭШИА |
| | 2.4.3. МУБИС-ийн судалгааны болон инновацын төслүүдээр бий болгосон мэдлэгийн хөрөнгө, дижитал брэндийг олон нийтэд сурталчлах маркетингийн тогтолцоог хөгжүүлэх. | Дижитал брэндийг олон нийтэд сурталчлах маркетингийн үйл ажиллагаа, тайлан | Дижитал брэндийг олон нийтэд сурталчлах маркетингийн тогтолцоогүй. | МУБИС-ийн маркетингийн тогтолцоог бүрдсэн байна. | I шат | Батлагдсан төсөв болон санхүүгийн бусад эх үүсвэр, ЭШИА |
| **3. Мэдлэгийн хөгжүүлэлт** | | | | | | |
| **Зорилго 3.** Цахим, хосолсон сургалтын арга зүйг төгөлдөржүүлэх, сурах, сургах үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах үүднээс дижитал суралцахуй, багшлахуйг төлөвшүүлэх. | | | | | | |
| 3.1. Хөтөлбөр хөгжүүлэлт<br><br>**Хамрах хүрээ:** Хөтөлбөрийн | 3.1.1 МУБИС-ийн үйл ажиллагаанд цахим, хосолсон сургалтын дүрэм, журам, удирдамж, зөвлөмжийг | Шинээр боловсруулсан цахим, хосолсон сургалтын журам, удирдамж, зөвлөмж | "МУБИС-ийн цахим сургалтын журам", "МУБИС-ийн онлайн хичээлд тавигдах шаардлага" (МУБИС- | Цахим хосолсон сургалтын журам, онлайн хичээлд тавигдах шаардлагад тулгуурласан багш, | I шат | СХАГ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| дизайнчлал; Дижитал ур чадвар; Цахим шилжилтийн хөтөлбөр; Суралцахуйн дизайн; Суралцахуйн загвар; Суралцахуйн үр дүн; Суралцахуй ба багшлахуйн үнэлгээ; Чанарын баталгаажуулалт.<br><br>**Зорилт 3.1.** МУБИС-ийн бакалавр, магистр, доктор, нэмэлт сургалтын хөтөлбөрүүдийг цахим, хосолсон хэлбэрээр зохион байгуулах. | шинээр боловсруулж сургалтад нэвтрүүлэх. | | ийн ректорын 2024 оны А/85 дугаар тушаал)-ыг боловсруулан үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байна. | суралцагчдад зориулсан онлайн, хосолсон сургалтын удирдамж, зөвлөмж бий болгож, багшийн системд байрлуулна. | | |
| | 3.1.2. МУБИС-ийн цахим сургалтыг хэрэгжүүлэх онлайн курс хичээлийн нэгдсэн загварыг сайжруулах, хэрэглээнд нэвтрүүлж багш нар хичээл сургалтаа зохион байгуулах. | Онлайн курс хичээлийн нэгдсэн загвар | “МУБИС-ийн онлайн хичээлд тавигдах шаардлага”-д тусгагдсан. | Онлайн курс хичээлийн хөтөлбөрийн нэгдсэн загвар боловсруулсан байна. | I шат | СЦШХ |
| | 3.1.3. МУБИС-ийн багш боловсрол, мэргэжлийн хичээлийн үнэлгээний санг баяжуулах, сайжруулах, үнэлгээний даалгавар, тестийн хүндрэлийн түвшин, найдвартай байдал, тогтвортой чанарыг үнэлэх үнэлгээний нэгдсэн тайланг гаргаж хэвших. | МУБИС-ийн СУМС-ийн үнэлгээний тайлан бэлтгэх модуль | МУБИС-ийн СУМС-д үнэлгээний сан, шалгалт зохион байгуулах үйлчилгээтэй боловч үйл ажиллагаа нь жигдрээгүй. | Үнэлгээний даалгавар, тестийн хүндрэлийн түвшин, найдвартай байдал, тогтвортой чанарыг үнэлэх үнэлгээний нэгдсэн тайланг гаргах модулийг СУМС-д нэмж хөгжүүлсэн байна. | I шат | Батлагдсан төсөв болон санхүүгийн бусад эх үүсвэр, СХАГ |
| | 3.1.4. МУБИС-ийн бакалавр, магистр, докторын сургалтын хэрэгжсэн хөтөлбөрүүдийн үр | Бүх түвшний хэрэгжсэн сургалтын хөтөлбөрийг үнэлэх аргачлал, алгоритмыг агуулсан модуль | хэрэгжсэн хөтөлбөрийг сургалтын үнэлэх аргачлал, алгоритм байхгүй. | Бүх түвшний хэрэгжсэн сургалтын хөтөлбөрийг үнэлэх аргачлал, алгоритмыг агуулсан үйлчилгээг | II шат | Батлагдсан төсөв, СХАГ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | дүнг үнэлэх аргачлалыг боловсруулж, СУМС-д нэмэлт модулийг хөгжүүлэх. | | | СУМС-д нэмсэн байна. | | |
| 3.2. Дижитал суралцахуй<br><br>**Хамрах хүрээ:** Хүртээмжтэй байдал ба тэгш хамруулах боловсрол; Дижитал ур чадвар; Дижитал үеийн үр дүнтэй суралцагч; Е-портфолио; Уян хатан суралцахуй; Номын сан ба суралцахуйн нөөцүүд; Өөрийн удирдлагатай суралцахуй; Суралцагчийн прогресс; Суралцагчийг дэмжих; Судалгааны орон зай. | 3.2.1. МУБИС-ийн бүх түвшний суралцагчид нэвтрэх боломжтой нийтэд нээлттэй онлайн курсууд (МООС)-ийг хөгжүүлж, турших, туршсан үр дүнгээ тайлагнах, туршлагаа түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагаа зохион байгуулж хэвших. | Нийтэд нээлттэй МООС курс | - | МУБИС-ийн тэнхим тус бүр нийтэд нээлттэй онлайн курс МООС хичээл бэлтгэж турших, үр дүнгээ бусад тэнхим, багш нарт танилцуулсан байна. | I, II шат | Бүрэлдэхүүн сургууль |
| | 3.2.2. Суралцагчдын сургалтын процесс дахь өгөгдлүүдийг цуглуулж, тэдэнд ахиц дэвшлийг мэдээлэх, хугацааны төлөвлөлт хийх механизмыг сургалтын системд нэвтрүүлж хэвших. | СУМС-ийн суралцагчдын ирц, бие даалт, явцын үнэлгээний мэдээллийн анализ, өгөгдлийг харуулах үйлчилгээ | Зөвлөх багшид хариуцсан оюутнуудын судалж байгаа кредитийн мэдээлэл харагддаг. | Суралцагчдын ирц, бие даалт, явцын үнэлгээний мэдээллийг цуглуулах датаг харуулах үйлчилгээг СУМС-д нэмсэн байна. | I шат | Батлагдсан төсөв болон санхүүгийн бусад эх үүсвэр, СХАГ |
| **Зорилт 3.2.** МУБИС-ийн бүх түвшний суралцагчид сургалтын нөөцөд асинхрон ба синхрон байдлаар хандах боломжийг бий болгож, дижитал | 3.2.3. Номын сан ба системийн үйлчилгээ, дижитал нөөц, өгөгдлийн сан, зөвлөмж ба нэмэлт дэмжлэг туслалцаа зэргийг суралцагч биеэр болон зайнаас | Номын сан ба системийн үйлчилгээний цахим мэдээлэл, цахим үйлчилгээний хаяг холбоосууд | Номын сангийн цахим веб хуудас https://library.msue.edu.mn/<br>Цахим каталог http://www.catalog.msue.edu.mn, веб | Номын сан ба системийн үйлчилгээ сайжирна. | I шат | Батлагдсан төсөв, СЦШХ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| суралцахуй болон тэгш хамруулах боловсролыг бүхий л талаар дэмжсэн сургалтын орчныг бүрдүүлэх. | авч, ур дүнтэй суралцахад шаардлагатай дижитал мэдээллүүдэд саадгүй хандах боломжийг бүрдүүлэх. | | сайтын үйлчилгээ үзүүлж байгаа. | | | |
| | 3.2.4. Бие бялдар, оюун ухааны бэрхшээл болон хэл, шашин соёлын ялгаатай төрөл бүрийн хэрэгцээтэй суралцагчийн сонирхол, хэрэгцээнд тохирсон сургалтыг зохион байгуулах нөхцөлийг бүрдүүлэх. | Тэнхим бүрийн хөгжүүлсэн иж бүрэн онлайн курс хичээлийн тоо | МУБИС-ийн хэмжээнд 15 иж бүрэн онлайн курс хичээл байгаа. | Тэнхим бүр иж бүрэн онлайн курс хичээлийг хөгжүүлж сургалтад ашиглаж эхэлсэн байна. | I, II шат | Батлагдсан төсөв, Бүрэлдэхүүн сургууль |
| 3.3. Дижитал багшлахуй<br><br>**Хамрах хүрээ:** Үнэлгээ ба эргэх холбоо; Хүртээмжтэй байдал ба тэгш хамруулах боловсрол; | 3.3.1. Виртуал хэлбэрээр болон бодитоор хийж гүйцэтгэх боломжтой практик, лабораторийн тоног, төхөөрөмж бүхий орчныг бүрдүүлэх. | МУБИС-ийн виртуал лаборатори (1-2) | МУБИС-ийн хэмжээнд виртуал лаборатори байхгүй. | МУБИС-ийн хэмжээнд 1-2 виртуал лабораторийг хөгжүүлнэ. | I, II шат | СЦШХ |
| Дижитал ур чадвар; Өгөгдлийн аналитик; Сургалтын технологи; Номын сан ба суралцахуйн нөөц; Нээлттэй боловсролын практик; Нээлттэй эхийн нөөц; | 3.3.2. Багш нарт онлайн курс хичээлийг бүтээх, зохион байгуулах, үнэлэх дижитал ур чадварыг бий болгох, хөгжүүлэх сургалтыг зохион байгуулах. | Бүрэлдэхүүний сургууль бүрийн зохион байгуулсан сургалтын тоо | Бүрэлдэхүүний сургууль жил бүр сургалт зохион байгуулах давтамж цөөн | Багш нар онлайн курс хичээлийг бүтээх, зохион байгуулах, үнэлэх түвшний дижитал ур чадвартай болсон байна. | I, II шат | СЦШХ, Бүрэлдэхүүн сургууль |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Багшийн хөгжил; Багшийн дэмжлэг.<br><br>**Зорилт 3.3.** МУБИС-ийн багш нар дижитал төхөөрөмж, мэдээлэл, орчин ба систем, аппликейшн зэргийг ашиглан цахим болон хосолсон сургалтыг зохион байгуулах дижитал багшлахуйг нэвтрүүлэх. | 3.3.3. Багш нарын боловсруулсан сургалтын цахим хэрэглэгдэхүүнийг МУБИС-ийн болон ЕБС-ийн багш нарт хүргэх үйлчилгээ бүхий өргөтгөлийг сургалт удирдлагын системд нэмэх. | СУМС-д багшийн модулийн цахим хэрэглэгдэхүүн байршуулах шинэ үйлчилгээ | СУМС-д багшийн цахим хэрэглэгдэхүүн байршуулах боломжтой хэдий ч бусад багш нар хандах боломжгүй. | Багшийн цахим хэрэглэгдэхүүнийг бусад багш нар үзэх боломжтой эсэхийг шийддэг үйлчилгээг СУМС-д нэмэх | II шат | СЦШХ |
| | 3.3.4. Суралцагч, бусад багш нар, удирдлага зэргээс багшид санал хүсэлт өгөх, эргэх холбоо үүсгэх модулийг хөгжүүлэх. | СУМС-ийн онлайн хичээлийн талбарт ажиглагч (Суралцагч, бусад багш нар, удирдлага) санал хүсэлт өгөх, эргэх холбоо үүсгэх шинэ үйлчилгээ | СУМС-д оюутны сэтгэл ханамжийн судалгаа авах, багшид өгөх үнэлгээний хэсэгтэй. | СУМС-ийн онлайн хичээлийн талбарт ажиглагч (Суралцагч, бусад багш нар, удирдлага) санал хүсэлт өгөх, эргэх холбоо үүсгэх шинэ үйлчилгээ нэмсэн байна. | I шат | СЦШХ |
| 3.4. Суралцагчийн туршлага<br><br>**Хамрах хүрээ:** Хүртээмжтэй байдал ба тэгш хамруулах боловсрол; Дижитал нийгэмлэг; Дижитал оролцоо; Дижитал сайн сайхан байдал; Оюутны туршлага; Оюутны дэмжлэг. | 3.4.1. Дижитал суралцахуйн туршлагын суурь түвшнийг тодорхойлох, жишиг тогтоож, суралцагчдыг хөгжүүлэхэд ашиглах. | Суралцагчдын ирц, идэвх оролцоо, бие даалт, явцын үнэлгээний суурь түвшнийг тодорхойлох аргачлал | Суралцагчдын суралцахуйн үнэлгээний шинжилгээ хангалтгүй. | Суралцагчдын ирц, идэвх оролцоо, бие даалт, явцын үнэлгээний суурь түвшнийг тодорхойлж, түүнд үндэслэн суралцагчдын суралцах арга замыг чиглүүлэх системийн шийдлийг хөгжүүлсэн байна. | II шат | СЦШХ |
| | 3.4.2. Дижитал мэдлэг, чадвараа хөгжүүлж, туршлагаа | Дижитал мэдлэг, чадвараа хөгжүүлсэн, туршлагаа бусдад | Сурлага, урлаг, спортын амжилт гаргасан | Дижитал чадавхаа хөгжүүлсэн, туршлагаа бусдад | I шат | ОХҮТ СЦШХ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 3.4.** МУБИС-ийн бүх түвшний суралцагчдад дижитал орчинд ажиллах туршлагыг олгож, бусдад түгээх, жишиг болгон ашиглах. | бусдад хуваалцсан суралцагчид кредитийн эсвэл нэмэлт сургалтын тэтгэлэг олгох, сертификат олгох зэргээр урамшуулах тогтолцоог бий болгох. | хуваалцсан суралцагчид кредитийн тэтгэлэг олгох, нэмэлт сургалтын тэтгэлэг олгох, сертификат өгөх зэргээр урамшуулахтай холбоотой оюутны журамд оруулсан заалтууд | суралцагчдад кредитийн тэтгэлэг олгодог. | хуваалцсан суралцагчдад кредитийн тэтгэлэг олгох, нэмэлт сургалтын тэтгэлэг олгох, сертификат олгох зэрэг урамшуулах заалтыг оюутны журамд оруулсан байна. | | |
| | 3.4.3. Оюутнуудын элсэлтээс төгсөлт хүртэлх хугацаанд тогтвортой, найдвартайгаар дижитал туршлага хуримтлуулах технологийн орчныг бүрдүүлэх. | Оюутны элсэлтээс төгсөлт хүртэлх хугацаанд гүйцэтгэсэн үйл бүрийн түүхийг дижитал туршлага болгон хуримтлуулах технологийн орчны бүрдэлт | Оюутны элсэлт, хичээл сонголт 1, 2, дүн, төгсөлтийн мэдээллийг хадгалдаг. Харин, хичээлийн идэвх, оролцооны мэдээллийг хадгалдаггүй. | Оюутны элсэлтээс төгсөлт хүртэлх хугацаанд гүйцэтгэсэн үйл бүрийн түүхийг дижитал туршлага болгон хуримтлуулах технологийн орчныг бүрдсэн байна. | II шат | Батлагдсан төсөв, СЦШХ |

**4. Мэдлэгийн менежмент ба хэрэглээ**

**Зорилго 4.** МУБИС-ийн үйл явц, үр дүн, оролцогч талуудад нөлөөлөхүйц аливаа шийдвэр гаргалтад нөлөөлөх мэдээлэл, өгөгдлийг нэгтгэх, хадгалах, удирдах, хуваалцах, ашиглах боломжийг бүрдүүлэх

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 4.1. Мэдээллийн менежмент ба хэрэглээ<br><br>**Хамрах хүрээ:** Дижитал мэдээлэл; Дижитал медиа; Дижитал нөөц; Мэдээллийн стратеги; | 4.1.1. МУБИС-ийн мэдээллийг цуглуулах, цэгцлэх, хадгалах, хуваалцах, хандахад дагаж мөрдөх журмыг боловсруулах. | МУБИС-ийн мэдээллийг цуглуулах, цэгцлэх, хадгалах, хуваалцах, хандахад дагаж мөрдөх журам | Өгөгдлийг хадгалах тогтсон стандарт байгаагүйгээс үүдэн хуучин СУМС-ийн агуулгыг шинэ системд шилжүүлэх ажиллагаа удаашралтай байна. Өгөгдөл хадгалах | Бодлогын баримт бичгийг боловсруулж, үг бичиг баримтыг багш ажилтан, оюутнууд мөрдлөг болгон ажиллаж, өгөгдлийг системд байршуулах хадгалах | I шат | МУБИС СЦШХ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Мэдээллийн хадгалалт ба хайлт; Номын сан.<br><br>**Зорилт 4.1.** Мэдээлэл цуглуулах, цэгцлэх, хадгалах, хуваалцах үйл ажиллагааны арга барил, процедурыг хөгжүүлэх. | | | нэгдсэн стандарт байхгүй. | журмыг мөрддөг болно. | | |
| | 4.1.2. МУБИС-ийн өгөгдөл, мэдээллийн менежмент, оюуны өмчийн эрх, лиценз, дижитал нөөц, нээлттэй хэвлэл, боловсролын нээлттэй эх, мэдээллийн боловсрол, хадгалалт, суралцахуй, багшлахуйн нөөцийг дижитал болгох нэгдсэн агуулгын менежментийн систем (CMS)-ийн хөгжүүлэх. | МУБИС-ийн ном, хэвлэл, дижитал нөөцийн өгөгдлийг хадгалах, түгээх, агуулгын нэгдсэн систем | Сургуулийн төв серверийг жил бүр тогтмол нэмэгдүүлж байгаа ч серверийн хэмжээ сургуулийн үйл ажиллагааг бүрэн дүүрэн хангаж чадахгүй байна. МУБИС-ийн номын сангийн цахим ном, судалгааны ажлын сангийн ашиглалт хэрэглээ хангалтгүй. | МУБИС-ийн нэгдсэн агуулгын менежментийн системтэй болох | II шат | Батлагдсан төсөв болон санхүүгийн бусад эх үүсвэр, Номын сан, СЦШХ |
| | 4.1.3. Хосолсон болон судалгаанд суурилсан суралцахуйг дэмжих дижитал номын сан, архивыг баяжуулах, судалгаа, инновацын төслийн үр дүнг хадгалах, боловсруулах, худалдах, худалдан | МУБИС-ийн багш, эрдэмтний судалгаа болон инновацын төслийн үр дүнгийн цахим сан | МУБИС-ийн багш, эрдэмтний судалгаа болон инновацын төслийн үр дүнг цаасан хэлбэрээр хадгалдаг. | МУБИС-ийн багш, эрдэмтний судалгаа болон инновацын төслийн үр дүнг хадгалах, боловсруулах, худалдах, худалдан авах тогтолцоонд ахиц гарсан байна. | I шат | СЦШХ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | авах тогтолцоо бүрдүүлэх. | | | | | |
| 4.2. Өгөгдлийн менежмент ба хэрэглээ<br><br>**Хамрах хүрээ:** Кибер аюулгүй байдал; Өгөгдлийн архитектур; Өгөгдлийн аналитик; Өгөгдлийн нууцлал; Өгөгдлийн стратеги; Өгөгдлийн сангийн менежмент; Ёс зүй.<br><br>**Зорилт 4.2.** МУБИС-тай хамааралтай аливаа шийдвэрийг үр дүнтэй гаргахад өгөгдлийг цуглуулах, цэгцлэх, хадгалах, хамгаалах, хуваалцах тогтолцоо бүрдүүлэх. | 4.2.1. Үр ашигтай хөрөнгө оруулалт, хэрэгжилт, өгөгдлийн хадгалалт, хөрвүүлэлт, дүн шинжилгээ бүхий ухаалаг бизнесийн зарчимд тулгуурласан дижитал өгөгдлийн сангийн журмыг боловсруулах. | Өгөгдлийн хадгалалт ба хөрвүүлэлт, дүн шинжилгээ бүхий ухаалаг бизнесийн зарчимд тулгуурласан дижитал өгөгдлийн сангийн журам | МУБИС-д өгөгдлийг хадгалах, түгээх, борлуулахтай холбоотой дүрэм журам байхгүй. | Өгөгдлийн хадгалалт ба хөрвүүлэлт, дүн шинжилгээ бүхий ухаалаг бизнесийн зарчимд тулгуурласан дижитал өгөгдлийн сангийн журмыг боловсруулсан байна. | II шат | СЦШХ, ЭШИА |
| | 4.2.2. Уян хатан, найдвартай өгөгдлийн сангийн архитектур (өгөгдлийг цуглуулах, цэгцлэх, анализ хийх, ба ашиглахад зориулсан загвар, архитектур)-ийг боловсруулж, батлуулах | Боловсруулж батлуулсан өгөгдлийн сангийн архитектур | Өгөгдлийн сангийн нэгдсэн төлөвлөлт, архитектур байхгүй. | Өгөгдлийн сангийн архитектурыг боловсруулан батлуулсан байна. | I шат | МУБИС СЦШХ |
| | 4.2.3. Өгөгдлийн менежмент, суралцахуйн аналитикийн судалгааны болон инновацын төсөл, | Өгөгдлийн менежмент, суралцахуйн аналитикийн судалгааны болон инновацын төсөл, хөтөлбөрүүд, үр дүн | Өгөгдлийн менежмент, суралцахуйн аналитикийн судалгааны болон инновацын төсөл, | Өгөгдлийн менежмент, суралцахуйн аналитикийн судалгааны болон инновацын төсөл, | I, II шат | МУБИС ЭШИА |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | хөтөлбөрийг хэрэгжүүлэх. | | хөтөлбөрүүдэд хөрөнгө оруулалт бага. | хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд хөрөнгө оруулалт хийсэн байна. | | |
| | 4.2.4. МУБИС-ийн багш, албан хаагч, суралцагчид хувийн болон байгууллагын өгөгдлийг аюулгүй хамгаалах, цэгцлэх, архивлах, ашиглах ур чадварыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах. | МУБИС-ийн багш, албан хаагч, суралцагчдад зохион байгуулсан мэдээлэл, өгөгдлийг аюулгүй байдлын сургалтын тоо | МУБИС-ийн багш, албан хаагч, суралцагч бүрд хувийн болон байгууллагын өгөгдлийг аюулгүй байдлын чиглэлийн сургалт хангалтгүй. | МУБИС-ийн багш, албан хаагч, суралцагч бүрд хувийн болон байгууллагын өгөгдлийн аюулгүй байдал, түүнийг хамгаалах талаар сургалтууд зохион байгуулсан байна. | I, II шат | Батлагдсан төсөв, МУБИС |
| 4.3. Ухаалаг бизнес<br><br>**Хамрах хүрээ:** Суурь үзүүлэлт ба жишиг тогтоох; Ухаалаг бизнесийн стратеги; Бизнес эдийн засгийн тасралтгүй байдлын төлөвлөлт; Цахим шилжилтийн хөтөлбөр; Ёс зүйн тогтолцоо; Хэтийн төлөв; Мэдээллийн менежмент; Зах зээлийн ухаан; Нээлттэй ба ил тод байдал. | 4.3.1. МУБИС-ийн бизнес, эдийн засгийн өгөгдлийг цуглуулах, цэгцэлж, байгууллагын хэмжээнд нээлттэй, ил тод байдлыг төлөвшүүлэх. | МУБИС-ийн санхүүгийн мэдээллийн нээлттэй, ил тод байдлын нэмэгдсэн хувь | МУБИС нь шилэн данс, ХАСХОМ зэрэг санхүүгийн системийг ашигладаг. | МУБИС-ийн бизнес, эдийн засгийн өгөгдлийг цуглуулах, цэгцэлж, байгууллагын хэмжээнд нээлттэй, ил тод байдалд ахиц гарна. | I, II шат | МУБИС |
| | 4.3.2. Ухаалаг бизнесийн систем, бодлого, ба үйл ажиллагааны найдвартай, ёс зүйтэй, тогтвортой, хууль ёсны байдлыг баталгаажуулах тогтолцоо бүрдүүлэх. | E-book, онлайн хичээл, лекц, цахим хэрэглэгдэхүүн, төлбөртэй үйлчилгээний тоо | Анги танхимын түрээслэх, цахим контент боловсруулах тарифыг баталсан. | Ухаалаг бизнесийн систем, бодлого, ба үйл ажиллагааны найдвартай, ёс зүйтэй, тогтвортой, хууль ёсны байдлыг баталгаажуулах тогтолцоо дээшилнэ. | II шат | БШУЯ, төрийн болон хувийн хэвшил, МУБИС |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 4.3.** МУБИС-ийн эдийн засаг, бизнестэй холбоотой стратегийн зорилтуудыг хэрэгжүүлэх, томоохон бизнесийн шийдвэр гаргахад шаардлагатай мэдээлэл болон өгөгдлийг цуглуулах, менежмент хийх, ашиглах. | 4.3.3. Боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах, шинэ санаа хөгжүүлэх төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх эндаументын санг байгуулах, хянах тогтолцоо бүхий системийн модулийг хөгжүүлэх. | МУБИС-ийн эндаументын сан | Сургуулийн тэгш ойн хүрээд төгсөгчдөөс тодорхой хандив цуглуулдаг ч бүртгэл, зарцуулалтын тайлан дутмаг | МУБИС-ийн эндаументын сан бий болсон байна. | II шат | МУБИС |
| 4.4. Шийдвэр гаргалт<br><br>**Хамрах хүрээ:** Дижитал итгэлцэл; Дижитал нотлох баримт; Дижитал ур чадвар; Дижитал манлайлал; Дижитал алсын хараа; Асуудал шийдвэрлэх.<br><br>**Зорилт 4.4.** МУБИС-ийн стратегийн зорилтуудаа амжилттай хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төлөвлөгөө, | 4.4.1. Шийдвэр гаргалтад нөлөөлөх үйл ажиллагаа, түүний чанар, нийцлийг үнэлэх дижитал нотлох баримт цуглуулах систем, дижитал хэрэгслийг бүтээж, үр дүнтэй ашиглах. | Шийдвэр гаргалтад нөлөөлөх хурлын тэмдэглэл, нотлох баримтыг цуглуулах систем, дижитал хэрэгсэл | Хурлын тэмдэглэл, протоколыг цаасан хэлбэрээр архивлаж хадгалдаг. | Шийдвэр гаргалтад нөлөөлөх ба чанар, нийцлийг үнэлэх дижитал нотлох баримтыг цуглуулах систем, дижитал хэрэгслийг бүтээж, ашиглаж эхэлсэн байна. | II шат | Батлагдсан төсөв болон санхүүгийн бусад эх үүсвэр, МУБИС |
| | 4.4.2. Шийдвэр гаргахад оролцож буй оролцогч талуудын асуулт, хариулт, санал, шүүмж зэрэг нотлох баримтуудыг цуглуулах, хадгалах, солилцох дижитал тогтолцоог бүрдүүлэх. | Шийдвэр гаргалтад нөлөөлөх хурлын тэмдэглэл, нотлох баримтыг цуглуулах хадгалах, солилцох үйлчилгээ | Шийдвэр гаргахад оролцож буй оролцогч талуудын асуулт, хариулт, санал, шүүмж зэрэг нотлох баримтуудыг цуглуулах, хадгалах, солилцох уламжлалт тогтолцоотой. | Шийдвэр гаргахад оролцож буй оролцогч талуудын асуулт, хариулт, санал, шүүмж зэрэг нотлох баримтуудыг цуглуулах, хадгалах, солилцох дижитал үйлчилгээг нэвтрүүлж, | II шат | МУБИС |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| хөтөлбөртэй холбоотой шийдвэрүүдийг нотлох баримтыг цуглуулах, хадгалах, хуваалцах, үнэлэх тогтолцоог нэвтрүүлэх. | | | | ажиллаж эхэлсэн байна. | | |
| | 4.4.3. МУБИС-ийн дижитал дэд бүтэц, стратеги, хөтөлбөрийн шийдвэр гаргалтад багш, судлаач, суралцагчийг оролцуулах. | МУБИС-ийн дижитал дэд бүтэц, стратеги, хөтөлбөрийн шийдвэр гаргалтад суралцагч, багш, судлаачийн оролцооны ахиц | - | МУБИС-ийн дижитал дэд бүтэц, стратеги, хөтөлбөрийн шийдвэр гаргалтад багш, суралцагч, судлаачийн оролцох боломж нэмэгдсэн байна. | I, II шат | МУБИС |
| **5. Мэдлэгийн солилцоо ба түншлэл**<br>**Зорилго 5.** Харилцаа, хамтын ажиллагаа, олон нийтийн оролцоог хангахуйц МУБИС-ийн гадаад болон дотоод хамтын ажиллагааны нэгдсэн менежментийг бий болгох. | | | | | | |
| 5.1. Харилцаа<br><br>**Хамрах хүрээ:** Хүртээмжтэй байдал ба тэгш оролцоо; Дижитал харилцаа холбоо; Дижитал медиа; Дижитал сүлжээ; Маркетинг; Байгууллагын харилцаа холбоо; Нийгмийн сүлжээ. | 5.1.1. Дижитал соёлтой байгууллага болон төлөвших ардчилсан харилцааны хэв маягийг дэмжих, мэдлэг, туршлагаа солилцох, хуваалцах МУБИС-ийн дотоод сүлжээний программ хангамжийг хөгжүүлэх. | МУБИС-ийн багш, албан хаагчдын хоорондын харилцаа холбоог сайжруулах, хурдасгах найдвартай дотоод сүлжээ программ хангамж | Багш, ажилтнууд мэдлэг, туршлагаа солилцох, мэдээлэл дамжуулах, хуваалцах МУБИС-ийн дотоод сүлжээний программ хангамж байхгүй. | Дижитал соёлтой байгууллага болон төлөвших ардчилсан харилцааны хэв маягийг дэмжих, мэдлэг, туршлагаа солилцох, хуваалцах МУБИС-ийн дотоод сүлжээ программ хангамжийг хөгжүүлсэн байна. | I шат | Батлагдсан төсөв болон санхүүгийн бусад эх үүсвэр, МУБИС |
| **Зорилт 5.1.** МУБИС-ийн багш, албан хаагчдын хоорондын харилцаа холбоог сайжруулах, хурдасгахад дижитал | 5.1.2. Дижитал мэдээллийн хэрэгслээр хүндэтгэлтэй харилцахыг дэмжих, дижитал харилцааны ур чадварт суралцах, хүний нөөцийг чадавхжуулах. | Хүний нөөцийн чадавхжуулах сургалтын тоо | Нийт хүний нөөцөд дижитал харилцааны ур чадварын талаар тодорхой үйл ажиллагаа зохион байгуулдаггүй. | МУБИС-ийн хүний нөөц дижитал мэдээллийн хэрэгслээр хүндэтгэлтэй харилцах, дижитал харилцааны ур | I шат | СЦШХ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| технологи, сүлжээ ашиглах. | | | | мэдлэг, чадвар дээшилсэн байна. | | |
| 5.2. Хамтын ажиллагаа<br><br>**Хамрах хүрээ:** Хүртээмжтэй байдал ба тэгш оролцоо; Олон нийтийн хамтын ажиллагаа; Дижитал хамтын ажиллагаа; Гадаад харилцааны үйл ажиллагаа; Дотоод хамтын ажиллагаа; Оюутны хамтын ажиллагаа; Төгсөгчдийн хамтын ажиллагаа.<br><br>**Зорилт 5.2.** МУБИС-ийн суралцагч, багш, албан хаагчдын дотоод хамтын ажиллагаа болон гадаад хамтын ажиллагаag дэмжих, хүртээмж, тэгш оролцоог хангахад дижитал технологийг ашиглах. | 5.2.1. Боловсролын нээлттэй эх, нийтэд нээлттэй онлайн курс хичээл, эрдэм шинжилгээний нийтлэл, бүтээл зэргээр дамжуулан мэдлэг түгээх, туршлага солилцохыг дэмжих. | МУБИС-ийн багш, судлаачдын боловсролын нээлттэй эх, нийтэд нээлттэй онлайн курс хичээл, эрдэм шинжилгээний нийтлэл, бүтээлийн түгээлтийн тоо | МУБИС-ийн багш, судлаачдын нээлттэй боловсролын эх, нийтэд нээлттэй онлайн курс хичээл, эрдэм шинжилгээний нийтлэл, бүтээлийн түгээн дэлгэрүүлэлт хангалтгүй. | МУБИС-ийн багш, судлаачдын нээлттэй боловсролын эх, нийтэд нээлттэй онлайн курс хичээл, эрдэм шинжилгээний нийтлэл, бүтээлийг дижитал технологийн тусламжтайгаар түгээн дэлгэрүүлдэг болсон байна. | I, II шат | МУБИС |
| | 5.2.2. Гадаадын их сургуультай хамтарсан хөтөлбөрийг уян хатан байдлаар хэрэгжүүлэх боломжтой цахим болон хосолсон сургалтын шийдлийг гаргах, зохион байгуулах. | Гадаадын их сургуультай хамтарсан цахим болон хосолсон сургалтын шийдэл, хэрэгжүүлсэн сургалтын тоо | Гадаадын их сургуультай хамтарсан хөтөлбөр хангалтгүй. | Гадаадын их сургуультай хамтарсан уян хатан байдлаар хэрэгжүүлэх боломжтой цахим болон хосолсон сургалтын шийдэл гаргаж, хэрэгжүүлж эхэлсэн байна. | II шат | ГХА СХАГ |
| 5.3. Олон нийтийн оролцоо | 5.3.1. МУБИС-ийн нийт багш, албан | МУБИС-ийн нийт багш, албан хаагчдыг аливаа | Аливаа үйл ажиллагаа, шийдвэр | МУБИС-ийн нийт багш, албан хаагчдыг | II шат | Батлагдсан төсөв болон |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **Хамрах хүрээ:** Хүртээмжтэй байдал ба тэгш оролцоо; Дижитал нийгэмлэг байгуулах; Дижитал оролцоо; Нийгмийн бүлэг; Бүс нутгийн хөгжил; Хамт байгаа мэт мэдрэмж.<br><br>**Зорилт 5.3.** МУБИС-ийн суралцагч, багш, албан хаагчдын нийгэмд чиглэсэн ажлын оролцоог дэмжих, урамшуулах, дижитал оролцооны тэгш, хүртээмжтэй байдлыг хангах. | хаагчдыг аливаа үйл ажиллагаа, шийдвэр гаргалтад оролцох, зөвлөлдөх, тэгш, хүртээмжтэй оролцоог дэмжих дижитал үйлчилгээ нэвтрүүлэх. | үйл ажиллагаа, шийдвэр гаргалтад татан оролцох, зөвлөлдөх, тэгш, хүртээмжтэй оролцоог дэмжих дижитал үйлчилгээ | гаргалтад оролцох, зөвлөлдөх, тэгш, хүртээмжтэй оролцоо хангалтгүй | аливаа үйл ажиллагаа, шийдвэр гаргалтад оролцох, зөвлөлдөх, тэгш, хүртээмжтэй оролцоог дэмжих дижитал хэрэгслийг боловсруулж, ашиглаж эхэлсэн байна. | | санхүүгийн бусад эх үүсвэр, МУБИС |
| | 5.3.2. МУБИС-ийн суралцагч олон нийтийн үйл ажиллагаанд өөрийн хүсэл сонголт сонирхлоор идэвхтэй оролцох системийн модулийг хөгжүүлэх. | МУБИС-ийн суралцагч олон нийтийн үйл ажиллагаанд өөрийн сонголт сонирхлоор, идэвхтэй оролцох системийн үйлчилгээ | Оюутанд олон нийтийн үйл ажиллагааг мэдээлэх, оролцох үйлчилгээ СУМС-д байхгүй | МУБИС-ийн суралцагч олон нийтийн үйл ажиллагаанд өөрийн сонголт сонирхлоор оролцох үйлчилгээг СУМС-д нэмж хөгжүүлсэн байна. | I шат | Батлагдсан төсөв болон санхүүгийн бусад эх үүсвэр, СЦШХ, ОХҮТ |
| | 5.3.3. Бүс, орон нутаг, олон улсын оролцогч талуудын хамтын ажиллагаа, түншлэлийг дэмжих, оролцоог хангах системийн үйлчилгээг хөгжүүлж ашиглах. | Бүс, орон нутаг, олон улсын оролцогч талуудын хамтын ажиллагаа, түншлэлийг дэмжих, оролцоог хангах СУМС-ийн үйлчилгээ | СУМС-д оролцогч талуудын хамтын ажиллагаа, түншлэлийг дэмжих үйлчилгээ байхгүй. | Бүс, орон нутаг, олон улсын оролцогч талуудын хамтын ажиллагаа, түншлэлийг дэмжих, оролцоог хангах системийн үйлчилгээг хөгжүүлж, хэрэгжүүлсэн байна. | II шат | Батлагдсан төсөв, МУБИС |
| | 5.3.4. Олон нийтийн ба сайн дурын нийгэмлэгүүдтэй хамтран ажиллах, хэрэглээ, практикт суурилсан болон суурь | Төслийн үр дүн, мэдлэг, туршлагыг түгээн дэлгэрүүлэх нөлөөллийн ажлын тоо | Олон нийтийн ба сайн дурын нийгэмлэгүүдтэй хамтран ажиллах, судалгааны үр дүнг түгээн дэлгэрүүлэх | Олон нийтийн ба сайн дурын нийгэмлэгүүдтэй хамтран ажиллах, судалгааны төслүүдийн үр дүн, | I, II шат | МУБИС |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | судалгааны ажлуудын үр дүн, мэдлэг, туршлагыг дамжуулах замаар нийгмийн нөлөөллийн ажлыг тогтмолжуулах. | | нөлөөллийн ажил тогтмолжоогүй. | мэдлэг, туршлагыг дамжуулах, нөлөөллийн ажлыг зохион байгуулсан байна. | | |
| 5.4. Харилцаа, хамтын ажиллагааны менежмент<br><br>**Хамрах хүрээ:** Бизнес ба үйлдвэрлэл; Хэрэглэгчийн харилцаа; Ажил олгогчийн харилцаа; Төгсөгчийн харилцаа; Хүний нөөц; Олон улсын үйл ажиллагаа; Нийгмийн бүлэг; Түншлэл; Оролцогч талуудын оролцоо.<br><br>**Зорилт 5.4.** МУБИС-ийн түншүүдийн оролцоог бий болгох, санал хүсэлт хялбар авах, оролцогч талуудын хоорондох түргэн шуурхай харилцааг бий болгох, хадгалахад дижитал технологийг ашиглах. | 5.4.1. МУБИС-ийн богино, дунд, урт хугацааны стратегийн болон цахим шилжилтийн хөтөлбөрийн зорилтуудыг хэрэгжүүлэх үүднээс дотоод болон гадаад оролцогч талууд (жишээ нь, ажил олгогч, бизнес эрхлэгч, судлаач, суралцагч, төгсөгч)-тай хамтран ажиллах, уялдаа холбоотой харилцах харилцааны менежментийн стратегийг боловсруулж, хэрэгжүүлэх. | Дотоод, гадаадын оролцогч талуудтай хамтран ажиллах, уялдаа холбоотой харилцах харилцааны менежментийн стратеги | Харилцаа, хамтын ажиллагааны менежментийн стратеги хангалтгүй. | Цахим шилжилтийн хөтөлбөрийн зорилтуудыг хэрэгжүүлэхийн тулд дотоод, гадаад оролцогч талуудтай хамтран ажиллах, уялдаа холбоотой харилцах харилцааны менежментийн стратегийг боловсруулж, хэрэгжүүлж эхэлсэн байна. | II шат | МУБИС |
| | 5.4.2. МУБИС-ийн төгсөгчдийг судлах, эргэх холбоо тогтоох, сургалт зохион байгуулах системийн модулийг хөгжүүлэх. | Төгсөгчдийг бүртгэх, эргэх холбоо тогтоох, сургалт явуулах системийн үйлчилгээ | Одоогоор төгсөгчдийг бүртгэлжүүлэх, эргэх холбоо тогтоох үйл ажиллагаа хангалтгүй. | МУБИС-ийн төгсөгчдийг судлах, эргэх холбоо тогтоох, мэргэшүүлэх сургалт зохион байгуулах системийн модулийг | I шат | Батлагдсан төсөв, СХАГ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | хөгжүүлж, үйл ажиллагаанд оруулсан байна. | | |
| **6. МУБИС-ийн дижитал дэд бүтэц**<br>**Зорилго 6.** МУБИС-ийн дижитал соёлыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, нэгдсэн менежментийн тогтолцооны өгөгдлийг нөөцлөх, хадгалах, ашиглах дижитал дэд бүтцийг байгуулах. | | | | | | |
| 6.1. Хүчирхэг дижитал дэд бүтэц<br><br>**Хамрах хүрээ:** Хэтийн төлөв; Дижитал орчин; Сүлжээ; Дижитал манлайлал; Засаглал; Мэдээллийн технологийн хөгжлийн бодлого; Оролцогч талуудын оролцоо; Application архитектур; Байгууллагын дижитал орчны архитектур; Хөрөнгө оруулалт; Тогтвортой байдал; Стандарт, шаардлагууд.<br><br>**Зорилт 6.1.** МУБИС-ийн үр ашигтай үйл ажиллагаа, хөгжлийг хурдасгах дижитал технологи, тоног төхөөрөмжийн | 6.1.1. Санхүү, цалин хөлс, хүний нөөц, маркетинг, оюутны элсэлт, хичээл сонголт, хичээлийн хуваарь, суралцагчийн ахиц дэвшил, туршлага, цахим болон хосолсон сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах зэрэг функцууд бүхий дижитал технологи бүхий үр ашигтай, өгөгдөлд суурилсан үйлчилгээг СУМС-д нэвтрүүлэх. | СУМС-ийн үйлчилгээний шинэчлэл | СУМС-д зарим үйлчилгээ нь хэрэглэгдэж байгаа. | Санхүү, цалин хөлс, хүний нөөц, маркетинг, оюутны элсэлт, хичээл сонголт, хичээлийн хуваарь, суралцагчийн ахиц дэвшил, туршлага, цахим болон хосолсон сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах зэрэг функцийг дэмждэг дижитал технологи бүхий үр ашигтай, өгөгдөлд суурилсан үйлчилгээг СУМС-д шинэчлэн нэвтрүүлнэ. | I шат | Батлагдсан төсөв болон санхүүгийн бусад эх үүсвэр, МУБИС |
| | 6.1.2. Сургалт удирдлага мэдээллийн системд AR/VR технологи зэрэг нийтлэг технологийг уялдуулах шийдэл нэвтрүүлэх. | СУМС дахь AR/VR нөөцийн тоо | "Сургалтын, удирдлага, мэдээллийн систем" - д AR/VR технологитой холболт байхгүй. | "Сургалтын, удирдлага, мэдээллийн систем"-д AR/VR технологийн шийдлийг нэгтгэсэн байна. | I, II шат | Гадаадын хөрөнгө оруулалт, МУБИС |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| шийдэл, аюулгүй, найдвартай цогц системийг төлөвлөх, хөрөнгө оруулалт, засвар үйлчилгээ хийх. | 6.1.3. Сургалт удирдлага мэдээллийн системийг боловсролын байгууллага, бусад их сургуулиудын системтэй мэдээлэл солилцох боломжтой өргөтгөл хийж хөгжүүлэх. | СУМС-ийн SCORM өргөтгөлийн хөгжүүлэлт | СУМС нь бусад их дээд сургуулийн системтэй өгөгдөл экспорт, импорт хийх боломж хязгаарлагдмал. | Бусад их дээд сургуулийн системтэй холбогдон мэдээлэл солилцох үйлчилгээг СУМС-д нэвтрүүлсэн байна. | I шат | Батлагдсан төсөв болон санхүүгийн бусад эх үүсвэр, МУБИС |
| | 6.1.4. МУБИС-ийн системд бие мах бодь, оюун ухааны, хэл яриа, сонсголын бэрхшээлтэй ялгаатай суралцагчид ашиглах боломжийг олгосон хөгжүүлэлтийг СУМС-д хийх. | СУМС-ийн шинэ үйлчилгээ | МУБИС-ийн СУМС-д бие мах бодь, оюун ухааны, хэл яриа, сонсголын зэрэг бэрхшээлтэй ялгаатай суралцагчид ашиглах боломж бага. | МУБИС-ийн СУМС-д бие мах бодь, оюун ухааны, хэл яриа, сонсголын зэрэг бэрхшээлтэй ялгаатай суралцагчид чөлөөтэй ашиглах хөгжүүлэлтийг хийсэн байна. | II шат | Батлагдсан төсөв болон санхүүгийн бусад эх үүсвэр, МУБИС |
| | 6.1.5. Лекцийн хичээлийн ирцийг автоматаар (WiFi эсвэл bluetooth) бүртгэх технологийн шийдлийг СУМС-д нэгтгэж, ашиглах. | Лекцийн хичээлийн ирцийг автомат бүртгэлийн үйлчилгээ | Лекцийн хичээлийн ирцийг багш гараар бүртгэж, системд оруулдаг. | Лекцийн хичээлийн ирцийг СУМС-д автоматаар бүртгэдэг болсон байна. | I шат | Батлагдсан төсөв болон санхүүгийн бусад эх үүсвэр, МУБИС |
| | 6.1.6. МУБИС-ийн өгөгдлийн санд цугласан мэдээлэл, их өгөгдөлд хиймэл оюун ухааны шийдлийг нэгтгэж ашиглах. | Хиймэл оюун ухааны шийдэл, үйлчилгээ | Хиймэл оюуны шийдлийг ашигласан туршлага байхгүй. | МУБИС-ийн өгөгдлийн санд цугласан мэдээлэл, их өгөгдөлд хиймэл оюун ухааны шийдлийг нэгтгэж | II шат | Батлагдсан төсөв болон санхүүгийн бусад эх үүсвэр, МУБИС |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | ашиглаж эхэлсэн байна. | | |
| | 6.1.7. МУБИС-ийн системийн үйлчилгээ, өгөгдөл, контентыг хадгалах кибер аюулгүй байдлын хамгаалалт, протоколуудыг ашиглан хийх, мэдээллийн нууцлал, бүрэн бүтэн байдлыг хханган, багш, ажилтан болон оюутнууд хаанаас ч сургалт удирдлагын систем, контентод хялбар, найдвартай нэвтрэх боломжийг бүрдүүлэх. | Кибер аюулгүй байдлын хамгаалалт | Одоо интернэт сүлжээний хамгаалалтын төхөөрөмж болох Firewall төхөөрөмжийн лиценз 2025 онд дууcна. | Сүлжээний хамгаалалтын төхөөрөмж болох Firewall төхөөрөмжийн лицензийг сунгаж шаардлагатай хамгаалалтын тохиргоог бүрэн хийнэ. | I шат | Батлагдсан төсөв болон санхүүгийн бусад эх үүсвэр, МУБИС СЦШХ |
| | 6.1.8. МУБИС-д шинэ систем, платформ, программ хангамжийг ашиглах, нэвтрүүлэх бодлого, архитектурыг боловсруулах. | МУБИС-ийн дижитал орчны архитектур | МУБИС-ийн дижитал орчны архитектур хийгдээгүй. | МУБИС-д шинэ систем, платформ, программ хангамжийг ашиглах, нэвтрүүлэх бодлого, архитектурыг боловсруулна. | I шат | МУБИС |
| | 6.1.9. МУБИС-ийн дижитал дэд бүтцэд эрсдэлийн үнэлгээг хийж, технологийн шинэчлэлийг цаг тухайд нь хийх. | Мэдээллийн аюулгүй байдлын аудитын дүгнэлт, тайлан | Мэдээллийн технологийн дэд бүтцэд 2019 оноос хойш эрсдэлийн үнэлгээ хийгдээгүй. | Мэдээллийн технологийн дэд бүтэц болон мэдээллийн аюулгүй байдалд аудит хийлгэсэн байна. | II шат | Батлагдсан төсөв болон санхүүгийн бусад эх үүсвэр, МУБИС |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 6.2. Дижитал сүлжээ<br><br>**Хамрах хүрээ:** Хүртээмжтэй байдал; Дижитал орчин; Кибер аюулгүй байдал; Дижитал сүлжээ; Найдвартай ба тасралтгүй байдал.<br><br>**Зорилт 6.2.** МУБИС-ийн санхүүгийн үйл явц, өгөгдлийн сангийн найдвартай үйл ажиллагааг хангах, дотоод болон гадаад сүлжээний шийдлийг сайжруулах. | 6.2.1. МУБИС-ийн онлайн үйлчилгээний одоогийн болон ирээдүйн төсөөлж буй эрэлт хэрэгцээг хангах хангалттай хүчин чадалтай, өндөр хурдтай өргөн зурвасын сүлжээний холболтыг бий болгох. | Өндөр хурдтай өргөн зурвасын сүлжээ | Сургууль хоорондын сүлжээний хурд 1Gbps хурдаар холбогдож байна. | Бүрэлдэхүүн сургууль бүрийн давхруудад байгаа сүлжээний төхөөрөмжийг 10Gbps дэмждэг төхөөрөмжөөр сольж сүлжээний хурдыг 10 дахин нэмэгдүүлнэ. | II шат | Батлагдсан төсөв болон санхүүгийн бусад эх үүсвэр, МУБИС |
| | 6.2.2. Олон түвшинт баталгаажуулалт, нууц үгийн хэрэгсэл, сүлжээний халдлага илрүүлэх, хянах, ransomware хамгаалалтын программ хангамж, WIFI сүлжээний хамгаалалт зэрэг дижитал аюулгүй байдлын арга хэмжээг өргөжүүлэх, шинэчлэх, нэвтрүүлэх. | Хамгаалалтын лицензтэй программ хангамжийн тоо | Серверүүд болон багш ажилтны компьютерын ихэнх нь лицензтэй программ хангамж байхгүй. | Багш ажилчдын ашиглаж байгаа компьютерыг Windows edu лицензтэй болгоно. МУБИС-ийн сүлжээг хамгаалах Ransomware хамгаалалтын программ хангамжийг хэрэглээнд нэвтрүүлнэ. | I, II шат | Батлагдсан төсөв болон санхүүгийн бусад эх үүсвэр, МУБИС |
| | 6.2.3. МУБИС-ийн СУМС-д ухаалаг утас, зөөврийн хэрэгслээс хялбар хандах аппликейшн хөгжүүлж, хэрэглээнд нэвтрүүлэх. | СУМС-ийн аппликейшн байдлаар хөгжүүлсэн үйлчилгээний тоо | МУБИС-ийн СУМС-д интернэт хөтөч ашиглан компьютер, утаснаас хандах боломжтой. СУМС-ийн аппликейшн хөгжүүлэгдээгүй. | МУБИС-ийн СУМС-ийн аппликейшн хөгжүүлж, хэрэглээнд нэвтрүүлнэ. | I, II шат | Батлагдсан төсөв болон санхүүгийн бусад эх үүсвэр, МУБИС |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 6.2.4. МУБИС-ийн сүлжээний инженерийг кибер аюулгүй байдал, сүлжээний хамгаалалтын сургалтад хамруулах, хөгжүүлэх. | МУБИС-ийн сүлжээний инженерийг кибер аюулгүй байдал, сүлжээний хамгаалалтын сургалтад хамрагдсан мэргэжилтний тоо | Аюулгүй байдал, сүлжээний хамгаалалтын сургалтад хамрагдсан мэргэжилтэн байхгүй | МУБИС-ийн сүлжээний инженерийг Cisco CCNA болон CCNP сургалтад хамруулсан байна. | I, II шат | Батлагдсан төсөв, МУБИС |
| 6.3. Дижитал дэмжлэг<br><br>**Хамрах хүрээ:** Дижитал мэргэжилтэн; Дижитал чадавх; Сургалтын технологич; Цахим багш; Орлоготой суралцагч; Багшийн дэмжлэг; Оюутны дэмжлэг; Засвар үйлчилгээ.<br><br>**Зорилт 6.2.** МУБИС-ийн систем, дижитал технологийг ажил, суралцахуй, багшлахуй, судалгаа шинжилгээнд үр дүнтэй ашиглахад туслах зорилготой тусламж, үйлчилгээг нэвтрүүлэх. | 6.3.1. МУБИС-ийн мэдээллийн технологийн тусламж, үйлчилгээний дижитал системийг сайжруулах, үйл ажиллагааг бэхжүүлэх. | Тусламж, үйлчилгээний дижитал системийн сайжруулсан үйлчилгээ | https://help.msue.edu.mn/ системийг ашиглан багш, ажилчид компьютерын засвар үйлчилгээ, office 365, албаны е-мэйл үйлчилгээ зэргийг авдаг. | МУБИС-ийн мэдээллийн технологийн тусламж, үйлчилгээний дижитал системийг сайжруулж үйл ажиллагааг тогтмолжсон байна. | I шат | Батлагдсан төсөв болон санхүүгийн бусад эх үүсвэр, МУБИС |
| | 6.3.2. МУБИС-ийн мэдээллийн технологийн тусламж, үйлчилгээг зайнаас синхрон болон асинхрон хэлбэрээр авах боломжийг бүрдүүлэх. | МУБИС-ийн мэдээллийн технологийн тусламж, үйлчилгээний синхрон болон асинхрон үйлчилгээний тоо | МУБИС-ийн мэдээллийн технологийн тусламж, үйлчилгээг ихэвчлэн биечлэн үзүүлдэг. | МУБИС-ийн мэдээллийн технологийн тусламж, үйлчилгээг зайнаас синхрон болон асинхрон хэлбэрээр авах боломжийг бүрдүүлнэ. | I, II шат | МУБИС |
| | 6.3.3. Мэдээллийн технологийн үйлчилгээг дижитал суралцахуй, багшлахуй, судалгаа, өгөгдлийн аналитик чиглэлээр өргөтгөх. | Өгөгдлийн аналитикийн үйлчилгээний тоо | https://help.msue.edu.mn/ системийг ашиглан компьютерын засвар үйлчилгээ, office 365, албаны е-мэйл үйлчилгээ зэргийг багш, ажилчид авдаг. | Мэдээллийн технологийн үйлчилгээг дижитал суралцахуй, багшлахуй, судалгаа, өгөгдлийн аналитик чиглэлээр өргөтгөнө. | I, II шат | Батлагдсан төсөв, МУБИС |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 6.4. Үл хөдлөх хөрөнгийн менежмент<br><br>**Хамрах хүрээ:** Дижитал стратеги; Байгаль орчны тогтвортой байдал; Үл хөдлөх хөрөнгийн менежмент; Ухаалаг кампус; Мэдээллийн технологийн хөгжлийн бодлого; Сургалтын орчин; Номын сан ба сургалтын нөөц.<br><br>**Зорилт 6.4.** Сургалтын дижитал орчны шаардлагыг хангасан анги, танхим, лабораторийг үе шаттай байгуулах, хөгжүүлэх. Виртуал кампус бүтээх, МУБИС-ийн үйл ажиллагаатай уялдуулах | 6.4.1. МУБИС-ийн биет болон виртуал дэд бүтцийг нэгтгэсэн үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийг бий болгох. | МУБИС-ийн үл хөдлөх хөрөнгийн бүртгэл | МУБИС-ийн биет үл хөдлөх хөрөнгийн бүртгэл акт хэлбэрээр цаасан дээр хийгддэг. | МУБИС-ийн биет болон виртуал дэд бүтцийг нэгтгэсэн үл хөдлөх хөрөнгийн бүртгэлтэй болсон байна. | II шат | МУБИС |
| | 6.4.2. МУБИС-ийн сүлжээнд холбогдсон дижитал тоног, төхөөрөмжийн насжилт, ашиглалтын талаарх нэгдсэн мэдээллийг үүсгэх, нийт багш, ажилчдад нээлттэй болгох. | Дижитал тоног, төхөөрөмжийн насжилт, ашиглалтын талаарх нэгдсэн мэдээлэл | Бүх сургуулиас жил болгон google forum ашиглан тоног төхөөрөмжийн судалгаа авдаг. | Тоног, төхөөрөмжийн насжилт, ашиглалтын талаарх нэгдсэн мэдээллийн сантай болно. | I шат | МУБИС |
| | 6.4.3. Оюутнууд, үйлчлүүлэгч, гадаад зочид төлөөлөгч нар МУБИС-ийн кампустай танилцах, зочлох, виртуал аялалд зориулсан виртуал кампусыг хөгжүүлж, хэрэглээнд оруулах | МУБИС-ийн виртуал кампус | МУБИС-ийн виртуал кампус https://de-center.msue.edu.mn/ холбоосоор ажиллаж байгаа. Түүх, нэмэлт мэдээллээр баяжуулах шаардлагатай. | Оюутнууд, үйлчлүүлэгч, гадаад зочид төлөөлөгч нар МУБИС-ийн кампустай танилцах, зочлох, виртуал аялалд зориулсан виртуал кампусыг хөгжүүлж, хэрэглээнд оруулсан байна. | II шат | Гадаадын хөрөнгө оруулалт, МУБИС |
| | 6.4.4. Хосолсон сургалтыг зохион байгуулах hybrid ангиудыг байгуулж, сургалтад ашиглах | Hybrid ангийн тоо | Нийт сургуулийн хэмжээнд 10ш hybrid анги байгуулсан. Багш нар ихэнхдээ танхимын сургалтад ашигладаг. | Хосолсон сургалтыг зохион байгуулах hybrid ангиудыг байгуулж, хосолсон сургалтад ашигладаг болсон байна. | I, II шат | Батлагдсан төсөв болон санхүүгийн бусад эх үүсвэр, МУБИС |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 6.4.5. Ганцаарчилсан болон бүлгийн онлайн хичээлийг зохион байгуулах акустик дуу тусгаарлагч бүхий хана, таазтай, AR/VR технологид суурилсан ухаалаг ангийг бий болгож, сургалтад ашиглах | AR/VR технологид суурилсан ухаалаг анги, танхимын тоо | AR/VR төхөөрөмж төв байрны студид нэг ширхэг байдаг. | Ганцаарчилсан болон бүлгийн онлайн хичээлийг зохион байгуулах акустик дуу тусгаарлагч бүхий хана, таазтай, AR/VR технологид суурилсан ухаалаг ангийг бий болгож, сургалтад ашиглаж эхэлсэн байна. | I, II шат | Батлагдсан төсөв болон санхүүгийн бусад эх үүсвэр, МУБИС |

**Зургаа. Гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлтүүд**

МУБИС-ийн цахим шилжилтийн хөтөлбөрийн ахиц дэвшлийг дараах гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлтээр хэмжих бөгөөд жил бүрийн гүйцэтгэлийг дараах байдлаар тодорхойлж байна.

| № | Үзүүлэлт (KPI) | Түлхүүр | 2025 | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Зорилт 1.1 Дижитал соёлыг хөгжүүлэх бүрдүүлсэн байдал | • Цахим шилжилтийн нэр томьёоны цахим тайлбар толь (тоогоор) | 1 | | | | | |
| | | • Бодлого, дүрэм, журмуудын интерактив сан (тоогоор) | | 1 | | | | |
| | | • МУБИС-ийн үйл ажиллагааны төлөвлөгөө, тайланг нэгтгэх, үнэлэх, хэвлэх систем (тоогоор) | | | 1 | | | |
| | | • Удирдлага, багш, ажилтны дижитал ур чадвараа хөгжүүлэх сургалтын болон зөвлөн туслах үйлчилгээний нэмэгдсэн хувь | 0 | 5 | 8 | 15 | 20 | 25 |
| | | • Шинэчилсэн ажлын байрны тодорхойлолтууд | | | * | * | * | |
| 2 | Зорилт 1.2 Нийгэм дэх нөлөөллийг нэмэгдүүлсэн байдал | • Байгууллагын эрхэм зорилго, үнэт зүйлс, ондоошлыг тусгасан танилцуулгын Монгол болон Англи хувилбар (багцаар) | | 1 | 1 | | | |
| | | • Зэрэг хандлагыг хөгжүүлэх, эрсдэлээс хамгаалах ажлууд, тайлан (жил бүрийн ажил, тоогоор) | 2 | 2 | 2 | 2 | 2 | 2 |
| 3 | Зорилт 1.3 Дижитал технологийг МУБИС-ийн үйл ажиллагаанд нэвтрүүлж буй байдал | • Цахим аюулгүй байдал, цахим дээрэлхэлд, ёс зүйн хэм хэмжээг ойлгуулах, ухааруулах сургалт, сурталчилгааны ажлын тоо | 1 | | 2 | | 3 | |
| | | • Бүрдүүлсэн эрүүл мэндэд ээлтэй ажлын байрны загвар, орчин | | | 1 | | | |
| | | • Хүний нөөцийн систем | | | 1 | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | Зорилт 1.4<br>Цахим шилжилтийн үйл ажиллагааны үр нөлөөг урьдчилан таамаглах байдал, хариу арга хэмжээний тоо | • Инновацыг дэмжих хөрөнгө (сая төгрөгөөр) | | 50,0 | 80,0 | 100,0 | 110,0 | 120,0 |
| | | • Удирдах ажилтны дижитал ур чадварын сургалт (тоогоор) | Жил бүр-1 | | | | | |
| | | • Инкубатор төв | | | 1 | | | |
| 5 | Зорилт 2.1<br>Дижитал технологийг хөгжүүлж, боловсролын үйлчилгээний чанарыг дээшлүүлэх ажил, сургалтын тоо | • МУБИС-ийн стратеги төлөвлөгөө болон Цахим шилжилтийн хөтөлбөрийн зорилтуудыг хэрэгжүүлэх нэгдсэн ойлголттой болох сургалт, семинар (тоогоор) | 3 | 3 | 2 | | | |
| | | • Боловсрол, бизнесийн салбар дахь дижитал өөрчлөлтүүдийн талаар сургалт, хэлэлцүүлэг (тоогоор) | 2 | 2 | 2 | | | |
| 6 | Зорилт 2.2<br>Эрдэм шинжилгээний дижитал системийн хөгжүүлэлт, хэрэглээний байдал | • Эрдэм шинжилгээний бүтээлийн бүртгэл, түгээлтийн систем | | 1 | | | | |
| | | • Бүтээн хэрэгжүүлж буй онлайн курс (тоогоор) | | 1 | 1 | 1 | 1 | 1 |
| | | • Судалгааны өгөгдлийн хадгалах, хэрэглэх стандарт (тоогоор) | | | 1 | | | |
| | | • Супер компьютерын үйлчилгээний нөхцөл, шаардлага | | | | | 1 | |
| | | • Ахисан түвшний суралцагчдын судалгааны менежмент хийх системийн модуль | | | | 1 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 7 | Зорилт 2.3<br>Дижитал манлайлал, инновацын бодлого, хөтөлбөрийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын хэмжээ, гарааны компанийн тоо | • Хэрэгжсэн инновацын төслүүдийн үр дүн, тайлан (жил бүр хэрэгжүүлэх тоогоор) | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 |
| | | • Батлагдсан журам, ажлын байрны тодорхойлолт (тоогоор) | * | | | | | |
| | | • Инновацын бүтээгдэхүүнд хөрөнгө оруулалт хийх төсвийн сан (сая төгрөгөөр) | 200,0 | | | | | |
| | | • Гарааны компанийн анхны хөрөнгө оруулалтын сан (сая төгрөгөөр), журам | | | | 500,0 | | 500,0 |
| 8 | Зорилт 2.4<br>Судалгааны болон инновацын төслийн тоо, үр дүн | • Судалгаа, үйлдвэрлэл болон бизнесийн инновацын төслүүдийн бүтээгдэхүүн, тайланд нөлөөллийн шинжилгээ хийсэн тайлан (тоогоор) | | | 1 | | | 2 |
| | | • Мэдээллийн технологийн мэргэжилтнүүдийг жил бүр хамрагдсан сургалтын тоо | 4 | 4 | 4 | 2 | 2 | 2 |
| | | • Дижитал брендийг олон нийтэд сурталчлах маркетингийн үйл ажиллагаа, тайлан (тоогоор) | | 1 | 1 | | | |
| 9 | Зорилт 3.1<br>Сургалтын хөтөлбөрийг цахим, хосолсон хэлбэрээр зохион байгуулах, СУМС дэх онлайн курс, хичээлийн тоо | • Шинээр боловсруулсан цахим, хосолсон сургалтын журам, удирдамж, зөвлөмж (тоогоор) | 1 | 1 | 1 | | | |
| | | • Онлайн курс хичээлийн хөтөлбөрийн нэгдсэн загвар (багц бүтээгдэхүүн, тоогоор) | 1 | | | | | |
| | | • СУМС-ийн үнэлгээний тайлан бэлтгэх модуль | | | 1 | | | |
| | | • Бүх түвшний сургалтын хэрэгжсэн хөтөлбөрийг үнэлэх аргачлал, алгоритмыг агуулсан СУМС-ийн модуль | | | | 1 | | |
| 10 | Зорилт 3.2<br>Дижитал суралцахуй болон тэгш хамруулах боловсролыг дэмжсэн | • Нийтэд нээлттэй (MOOC) онлайн курс | 2 | | 4 | | 6 | |
| | | • СУМС-ийн суралцагчдын ирц, бие даалт, явцын үнэлгээний мэдээллийн анализ, өгөгдлийг харуулах үйлчилгээ | | | 1 | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | сургалтын орчны бүрдэлт, хичээл, үйлчилгээний тоо | ● Номын сан ба системийн үйлчилгээний цахим мэдээлэл, цахим үйлчилгээний хаяг холбооснууд | | 1 | | | | |
| | | ● Тэнхим бүрийн хөгжүүлсэн иж бүрэн онлайн курс хичээлийн тоо | 20 | 25 | 30 | 35 | 40 | 45 |
| 11 | Зорилт 3.3<br>Цахим болон хосолсон сургалтыг зохион байгуулах дижитал багшлахуйг нэвтрүүлэх ажлын тоо | ● Виртуал лабораторийн тоо | | | 1 | | | 2 |
| | | ● Бүрэлдэхүүний сургууль бүрийн зохион байгуулсан сургалтын тоо | 15 | 15 | 16 | 16 | 18 | 18 |
| | | ● СУМС-д багшийн модулийн цахим хэрэглэгдэхүүн байршуулах шинэ үйлчилгээ | | | | 1 | | |
| | | ● СУМС-ийн онлайн хичээлийн талбарт ажиглагч (Суралцагч, бусад багш нар, удирдлага) санал хүсэлт өгөх, эргэх холбоо үүсгэх шинэ үйлчилгээ | | | 1 | | | |
| 12 | Зорилт 3.4<br>Суралцагчдад дижитал туршлагыг бий болгох чиглэсэн сургалт, ажлын тоо | ● Суралцагчдын ирц, идэвх оролцоо, бие даалт, явцын үнэлгээний суурь түвшнийг тодорхойлох аргачлал | | | | | 1 | |
| | | ● Дижитал мэдлэг, чадвараа хөгжүүлсэн, туршлагаа бусдад хуваалцсан суралцагчид кредитийн тэтгэлэг олгох, нэмэлт сургалтын тэтгэлэг олгох, сертификат өгөх зэргээр урамшуулахтай холбоотой оюутны журамд оруулсан заалтууд | | 1 | | | | |
| | | ● Оюутны элсэлтээс төгсөлт хүртэлх хугацаанд гүйцэтгэсэн үйл бүрийн түүхийг дижитал туршлага болгон хуримтлуулах технологийн орчны бүрдэлт | | | | * | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 13 | Зорилт 4.1 Мэдээлэл цуглуулах, хадгалах, төгөлдөршүүлэх үйл ажиллагаа, контент, нэгдсэн системийн тоо | • МУБИС-ийн мэдээллийг цуглуулах, цэгцлэх, хадгалах, хуваалцах, хандахад дагаж мөрдөх журам | | 1 | | | | |
| | | • МУБИС-ийн ном, хэвлэл, дижитал нөөцийн өгөгдлийг хадгалах, түгээх, агуулгын нэгдсэн систем | | | | | | 1 |
| | | • МУБИС-ийн багш, эрдэмтний судалгаа болон инновацын төслийн үр дүнгийн цахим сан | 1 | | | | | |
| 14 | Зорилт 4.2 Шийдвэр гаргалтад өгөгдлийг ашиглахад чиглэсэн дүрэм журам, хөрөнгө оруулалт, сургалт, ажлын тоо | • Өгөгдлийн хадгалалт ба хөрвүүлэлт, дүн шинжилгээ бүхий ухаалаг бизнесийн зарчимд тулгуурласан дижитал өгөгдлийн сангийн журам | | | | 1 | | |
| | | • Боловсруулж батлуулсан өгөгдлийн сангийн архитектур | | 1 | 1 | | | |
| | | • Өгөгдлийн менежмент, суралцахуйн аналитикийн судалгааны болон инновацын төсөл хөтөлбөрүүд, үр дүн | | 1 | | 2 | | 3 |
| | | • МУБИС-ийн багш, албан хаагч, суралцагчдад зохион байгуулсан мэдээлэл, өгөгдлийг аюулгүй байдлын сургалтын тоо | | 1 | 1 | 1 | 1 | 1 |
| 15 | Зорилт 4.3 Бизнестэй холбоотой стратегийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд өгөгдлийг ашиглах үйлчилгээний өртөг | • МУБИС-ийн санхүүгийн мэдээлэл нээлттэй, ил тод байдал нэмэгдсэн хувь | 10 | 20 | 25 | 30 | 40 | 50 |
| | | • E-book, онлайн хичээл, лекц, цахим хэрэглэгдэхүүн, төлбөртэй үйлчилгээний тооны өсөлт | | | | 1 | 2 | 3 |
| | | • МУБИС-ийн эндаументын сан | | | | 1 | | |
| 16 | Зорилт 4.4 Стратегийн зорилтуудтай | • Шийдвэр гаргалтад нөлөөлөх хурлын тэмдэглэл, нотлох баримтыг цуглуулах систем, дижитал хэрэгсэл | | | | | 1 | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | холбоотой шийдвэрийг нотлох баримтуудыг цуглуулах, хуваалцах, үнэлэх, тогтолцоог нэвтрүүлэх үйлчилгээний байдал | • Шийдвэр гаргалтад нөлөөлөх хурлын тэмдэглэл, нотлох баримтыг цуглуулах хадгалах, солилцох үйлчилгээ | | | | | | 1 |
| | | • МУБИС-ийн дижитал дэд бүтэц, стратеги, хөтөлбөрийн шийдвэр гаргалтад багш, судлаач, суралцагчийн оролцооны ахицын хувь | 20 | 25 | 30 | 40 | 50 | 60 |
| 17 | Зорилт 5.1<br>Харилцаа холбоог сайжруулахад дижитал технологийг нэвтрүүлэхэд чиглэсэн системийн хөгжүүлэлт, сургалтын тоо | • МУБИС-ийн багш, албан хаагчдын хоорондын харилцаа холбоог сайжруулах, хурдасгах дотоод сүлжээ программ хангамж | | | 1 | | | |
| | | • Хүний нөөцийг чадавхжуулах сургалтын тоо | 1 | 2 | 2 | | | |
| 18 | Зорилт 5.2<br>Гадаад болон дотоод хамтын ажиллагааг хөгжүүлэхэд дижитал технологийг нэвтрүүлэх шийдэл, хамтарсан сургалтын тоо | • МУБИС-ийн багш, судлаачдын боловсролын нээлттэй эх, нийтэд нээлттэй онлайн курс хичээл, эрдэм шинжилгээний нийтлэл, бүтээлийн түгээлтийн тоо | | | 1 | 2 | 3 | 4 |
| | | • Гадаадын их сургуультай хамтарсан цахим болон хосолсон сургалтын шийдэл, хэрэгжүүлсэн сургалтын тоо | | | | 1 | 1 | 2 |
| 19 | Зорилт 5.3<br>Дижитал технологийг ашиглан тэгш хүртээмжтэй байдлыг хангахад чиглэсэн системийн хөгжүүлэлт, | • МУБИС-ийн нийт багш, албан хаагчдыг аливаа үйл ажиллагаа, шийдвэр гаргалтад татан оролцуулах, зөвлөлдөх, тэгш, хүртээмжтэй оролцоог дэмжих дижитал үйлчилгээ | | | | | 1 | |
| | | • МУБИС-ийн суралцагч олон нийтийн үйл ажиллагаанд өөрийн сонголтоор, идэвхтэй оролцох системийн үйлчилгээ | | 1 | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | нөлөөллийн ажлын тоо | • Бүс, орон нутаг, олон улсын оролцогч талуудын хамтын ажиллагаа, түншлэлийг дэмжих, оролцоог хангах системийн үйлчилгээ | | | | | 1 | |
| | | • Төслийн үр дүн, мэдлэг, туршлагыг түгээн дэлгэрүүлэх нөлөөллийн ажлын тоо | | | 1 | | | 1 |
| 20 | Зорилт 5.4 Санал хүсэлтийг хурдан шуурхай авах, харилцаанд дижитал технологийг нэвтрүүлсэн байдал | • Дотоод, гадаадын оролцогч талуудтай хамтран ажиллах, уялдаа холбоотой харилцах харилцааны менежментийн стратеги | | | | 1 | | |
| | | • Төгсөгчдийг бүртгэх, эргэх холбоо тогтоох, сургалт явуулах системийн үйлчилгээ | 1 | | | | | |
| 21 | Зорилт 6.1 Дижитал технологийн хөрөнгө оруулалт, СУМС-ийг тасралтгүй хөгжүүлэх ажил, үйлчилгээний тоо | • СУМС-ийн үйлчилгээний шинэчлэл | | 1 | | | | |
| | | • СУМС дахь AR/VR нөөцийн тоо | | | 1 | 2 | 2 | 3 |
| | | • СУМС-ийн SCORM өргөтгөлийн хөгжүүлэлт | | 1 | | | | |
| | | • СУМС-ийн шинэ үйлчилгээ нэвтрүүлэлт | | | | 1 | | |
| | | • МУБИС-ийн их өгөгдөл дэх хиймэл оюун ухааны шийдэл, үйлчилгээ | | | | | 1 | 1 |
| | | • Лекцийн хичээлийн ирцийг автомат бүртгэлийн үйлчилгээ | 1 | | | | | |
| | | • Кибер аюулгүй байдлын хамгаалалтыг сунгах | | 1 | | | | |
| | | • МУБИС-ийн дижитал орчны архитектур | | 1 | | | | |
| | | • Мэдээллийн аюулгүй байдлын аудитын дүгнэлт, тайлан | | | | 1 | | |
| 22 | Зорилт 6.2 Сүлжээ, системийн найдвартай үйл ажиллагааг хангах, СУМС-ийн хэрэглэгчид ойртуулан хөгжүүлэхэд чиглэсэн | • Өндөр хурдтай өргөн зурвасын сүлжээ (Gbps-ээр) | | | | 5 | | 10 |
| | | • Сүлжээний хандалт, нууцлалын сайжруулалт | | 1 | | | | |
| | | • Хамгаалалтын лицензтэй программ хангамжийн тоо | | | | | 5 | |
| | | • СУМС-ийн аппликейшн байдлаар хөгжүүлсэн үйлчилгээний тоо | | 3 | 5 | 8 | 10 | 12 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ажил, үйлчилгээний тоо | • МУБИС-ийн сүлжээний инженерийг кибер аюулгүй байдал, сүлжээний хамгаалалтын сургалтад хамрагдсан мэргэжилтний тоо | 2 | | 3 | | 4 | |
| 23 | Зорилт 6.3 Дижитал технологийг үр дүнтэй ашиглах, тусламж үйлчилгээг нэвтрүүлэхэд ажлын тоо | • Тусламж, үйлчилгээний дижитал системийн сайжруулсан үйлчилгээ | | 1 | | | | |
| | | • МУБИС-ийн мэдээллийн технологийн тусламж, үйлчилгээний синхрон болон асинхрон үйлчилгээний тоо | | 1 | 1 | 2 | 2 | 3 |
| | | • Өгөгдлийн аналитикийн үйлчилгээний тоо | | 1 | 1 | 1 | 2 | 2 |
| 24 | Зорилт 6.4 Дижитал анги, танхим, лабораторийн орчныг сайжруулах, дижитал хөрөнгө, тоног төхөөрөмжийг шинэчлэх ажил, үйлчилгээний тоо | • МУБИС-ийн үл хөдлөх хөрөнгийн бүртгэл | | | | | | 1 |
| | | • Дижитал тоног, төхөөрөмжийн насжилт, ашиглалтын талаарх нэгдсэн мэдээлэл | 1 | | | | | |
| | | • МУБИС-ийн виртуал кампус | | | | | | 1 |
| | | • Hybrid ангийн тоо | 27 | 29 | 32 | 35 | 38 | 40 |
| | | • AR/VR технологид суурилсан ухаалаг анги, танхимын тоо | | 2 | 3 | | 4 | 5 |

## Долоо. ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

7.1. Бодлогын хэрэгжилтийн явцын тайланг жил бүрийн 12 дугаар сард багтаан хариуцсан нэгж, бүрэлдэхүүний сургуулиуд Сургалт, хамтын ажиллагааны газарт ирүүлнэ.

7.2. Бүрэлдэхүүний сургуулиудаас ирсэн тайланг Сургалт, хамтын ажиллагааны нэгтгэн дүгнэж, дараагийн жилийн үйл ажиллагаагаа ажлын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлнэ.

7.3. "МУБИС-ийн цахим шилжилтийн хөтөлбөр"-ын дунд хугацааны хэрэгжилтийн үнэлгээг 2028 онд хийж, хүрэх үр дүнг шинэчлэн 2030 он хүртэл хэрэгжүүлнэ.